

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний ХШҮ-ний тайлан

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
НЭГ.. КОВИД 19 ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1	1.1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээ	1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх			“Ковид-19” цар тахлын эрсдэлийг 50-аас дээш хувь бууруулсан байна.		Аймгийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 23442 ковидын халдвар бүртгэгдсэн. Үүнээс он гарснаас хойш 5848 тохиолдол бүртгэгдэж, нас баралт 2 гарсан. Дархлаажуулалтын 1-р тунд 57912 (89.5%), 2-р тунд 54657 (84.5%), 3-р тунд, 26970(57.6%), 4-р тунд 4347(9.3%) хувийн хамрагдалттай байна. Ковидын тархалтын үед 1153 ор дэлгэж, хариу арга хэмжээний 4 баг иргэдэд тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлсэн. Гамшгийн үеийн өндөржүүлсэн бэлэн	70%

						байдлыг 2022 оны 02 сарын 15-ныг хүртэл сунгаж, олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурим найр, хурал, зөвөлгөөн зохион байгуулахыг хязгаарлаж, одоо энгийн горимтой үйл ажиллагаа явагдаж байна.	
2		1.1.2. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулах			Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэдэд 20000 удаагийн давтамжтайгаар хүргэнэ.	Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, болон эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсуудаар дамжуулан Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна. Цахим сүлжээнд давхардсан тоогоор 10.000 хүнээс тандалт авч, мэдлэг мэдээлэл хүргэж ажилласан.	70%
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
3	2.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл	2.1.1. “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээг хэрэгжүүлэх			Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг 0.2 хувиар багасгана. Эрэгтэйчүүдийн кабинет байгуулж,	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг 4 жилээр боловсруулан 2022 оны 06 дугаар сард багтаж, аймгийн ЗДТГ-ын удирдах	30%

				<p>төрөлжсөн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</p>	<p>зөвлөлийн хурлаар оруулан батлуулахаар төлөвлөж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд эрэгтэйчүүд дийлэнх ажилладаг төрийн байгууллагууд, аймгийн МСҮТ-ийн эрэгтэй багш ажилчид, 1 ба 2 дугаар курсын оюутан залуучуудад “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү түүний шалтгаан” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 282 эрэгтэй албан хаагч хамрагдсан. Сургалтын өмнөх мэдлэг 20 хувь, дараах 70 хувь болж нэмэгдсэн үр дүнтэй сургалт болсон. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулахаар төлөвлөж, “Урологи, андрологийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч боловсон хүчинг бэлтгэж, ирэх 10 дугаар сард төгсөхөөр суралцаж байна. Эрэгтэйчүүдийн кабинет байгуулахад санхүүжилтийн асуудал одоогоор шийдэгдээгүй. 2021 оны байдлаар аймгийн хүн амын</p>
--	--	--	--	--	--

						дундаж наслалт 71.28 байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.17, эмэгтэйчүүдийнх 73.21 байгаа бөгөөд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 5.04-өөр бага байна. Цаашид Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлсэнээр эрэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөлийг бууруулах, хорт зуршлийн хэрэглээг багасгах, таргалалт, илүүдэл жин зохисгүй хооллолт зэрэг эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад гол анхаарлаа хандуулан, эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн төрөлжсөн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, орхигдоод байгаа эрүүл мэндийн асуудлуудад эерэг өөрчлөлт гарч, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.	
4		2.1.2. Аймгийн 18-аас дээш насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулах		Нийт иргэдийн 60-аас дээш хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх	Аймгийн хэмжээнд “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд” эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 1-р	50%	

				төлөвлөгөө гаргаж биелэлтийг ханган ажиллана.		улирлаас эхлэн Баян-Овоо, Шинэжинст, Баян-Өндөр сум болон Наранмандал, Оточмандал өрхийн ЭМТ-үүдэд, 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс “Эрүүл мэнд үндэсний баялаг” уриатай эрт илрүүлэх үзлэг оношилгоог зохион байгуулж, нийт 7414 иргэн хамрагдаж, хамрагдалт 8.3 хувьтай байгаа нь улсын дундажаас харьцангуй доогуур байна. Үзлэгээр дараагийн шатлалд эмчлүүлэх шаардлагатай иргэдийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, одоогийн байдлаар нэн яаралтай 6 өвчтөнг гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Иргэд үзлэг, шинжилгээнд хамрагдахдаар 0-5, 06-17 насны иргэд өрх сумын эрүүл мэндийн төвд, 18-30, 31-45, 46-60, 61-дээш насны иргэд аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн дэмжих төвд очиж үзлэгт хамрагдах үйл ажиллагаа хийгдэж эхлээд байна. Манай аймаг нь 89329 хүн амтай бөгөөд 2022 онд урьдчилан сэргийлэх эрт	
--	--	--	--	---	--	--	--

						<p>илрүүлэг үзлэгт нийт хүн амын 60 хувь буюу 0-17 насны 18140, 18-30 насны 9409, 31-45 насны 10713, 46-60 насны 7236, 61 дээш насны 3635, нийт 49133 иргэнийг үзлэг, оношлогоонд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Одоогоор эрт илрүүлэг үзлэг оношлогоог зохион байгуулахад нэгдсэн эмнэлгийн дэмжих төвийн засвар үйлчилгээ дуусаагүй, ашиглалтад ороогүй байгаа нь удаашруулж байна, уг дэмжих төвийг 06 дугаар сард ашиглалтад авахаар ажиллаж байна. 2022 онд бүтэн 1 жилийн хугацаанд иргэд өөрийн харьяаллын өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзлэгийн урилгыг авч, эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдана. Цаашид үзлэг оношилгоог эрчимжүүлэн ажиллахаар бүх шатны эмнэлгүүдэд чиглэл хүргэгдэж, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн эрт илрүүлэгтэй холбоотой салбар дундын хэлэлцүүлэг</p>	
--	--	--	--	--	--	--	--

						зохион байгуулагдсан, уг хэлэлцүүлгээс гарсан санал санаачилгаар бүх шатны нэгжүүдэд зөвлөмж хүргэгдэнэ.	
5		2.1.3. "Халдварын эрсдэлгүй ирээдүй" зорилтот төсөл хэрэгжүүлэх		Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг 5-10 хувиар бууруулна.		Баян-Овоо, Баян-Өндөр, Шинэжинст сумууд болон Оточномгон, Энхбүрд, Наранмандал өрхийн ЭМТ-үүдэд 15-64 насны зорилтот бүлгийн иргэдийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг 2022 оны 02 дугаар сарын 17-ноос 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хийгдсэн. Анхан шатны 6 нэгж байгууллагаас БЗДХ-ын үзлэг шинжилгээнд нийт 2973 иргэнийг хамруулж, нийт 326 өвчлөл шинээр илрүүлж эмчилэн, хавьтлын хамт нийтдээ 525 иргэнийг эмчилгээнд хамруулан зөвлөгөө өгсөн. Шинжилгээнд: ДОХ-ын тест 3006, Тэмбүүгийн тест -3006, нийт 6012 тест хэрэглэсэн ба 677 хүнд мазокийн шинжилгээ хийсэн. Нийт бүртгэгдсэн өвчлөлийг оношоор нь авч үзвэл: <input type="checkbox"/> Тэмбүү-21 <input type="checkbox"/> Заг хүйтэн -18 <input type="checkbox"/> Трихоминаз-18 <input type="checkbox"/> Нийт мөөгөнцөр- 171 <input type="checkbox"/>	50%

						<p>Бэлгийн замын бусад халдвар- 98 тус тус илэрч эмчилгээнд орсон. Шинээр жирэмсний хяналтад орсон 748 эмэгтэйчүүдийн 675 буюу 90.2 хувь нь трихомоназ, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, тэмбүү, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 99.8 хувь хамрагдаж трихомоназ 55, заг хүйтэн 10, тэмбүүгийн 11 эерэг тохиолдол оношлогдож эмчилгээнд хамруулсаныг 2021 оны мөн үетэй харьцуулахад заг хүйтэн, тэмбүүгийн өвчлөл нэмэгдсэн, трихомониаз өвчлөл буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд эхний 5 сард нийт 6350 халдварт өвчин бүртгэгдэж 10.000 хүн амд 705.8 байгааг 2021 оны мөн үетэй (58.9) харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн БЗДХ-ын тохиолдлын тоо нэмэгдэж, нийт халдварт өвчний 7.0 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 445 тохиолдлын 31.7 хувийг заг хүйтэн, 49.6 хувийг трихомониаз, 20.08 хувийг тэмбүүгийн өвчлөл тус тус</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>эзэлж байна. Тэмбүүгийн өвчлөл 10,3 промилл байгаа өнгөрсөн оны мөн үеэс 2,7 промиллоор ихэссэн, заг хүйтэн 15,7 промилл өнгөрсөн оны мөн үеэс 8,7 промиллоор ихэссэн, трихоминиаз 24,6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2,2 буурсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчний үзүүлэлт өссөн нь илрүүлэг үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж байгаатай шууд холбоотой юм.</p>	
6	2.1.4. Сурагчдын шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах			<p>Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн шүдний 6 эмнэлгийг түшиглэн, аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг үзлэг оношилгоонд үе шаттай хамруулж, илэрсэн өвчлөлийг 100 хувь эрүүлжүүлнэ.</p>	<p>“Хонгор дент” шүдний эмнэлэг, Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр арван жилийн сургууль, Баян-Ойт, Соого сейко сургуулиудын 12 насны 1200 сурагчийг шүдний үзлэг, оношилгоонд хамруулахаас 100 хувь хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Мөн Тус сургуулийн сурагчдад “Шүдний эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүүхэд багачуудад мэдлэг олгосон байна. Эрүүл мэндийн газрын 2018 оны</p>	70%	

						судалгаагаар сурагчдын дундах шүдний цооролын тархалт аймгийн хэмжээнд 86 хувьтай байсныг тус газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн “Эрүүл мэндийн сургалт, судалгаа шинжилгээний инновацийн алба”-наас хэрэгжүүлсэн Шүдний өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох судалгаатай харьцуулан гаргаж, дүгнэлтийг танилцуулахаар ажиллаж байна. Судалгаанд 600 гаруй сурагч хамрагдсан.	
7		2.1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг бэлтгэх		Нийгмийн эрүүл мэнд, тархвар судлаач, эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр 4 мэргэжилтнийг мэргэшүүлнэ.		Эрүүл мэндийн салбарын 120 нэгж байгууллагад нийт 1209 ажиллагсад ажиллаж байна. Үүнээс их эмч 194 буюу 16 хувь, сувилагч, тусгай мэргэжилтэн 536 буюу 44,5 хувийг эзэлж байна. Одоогоор шүдний эмч, тархвар судлаач, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, ахмадын эмч, багийн эмч дутагдалтай байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 2022 оны Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулан, 5 чиглэлээр	30%

						<p>12 эмч, сувилагч нарыг сургахаар шийдвэрлэсэн. Нийгмийн эрүүл мэнд, тархвар судлаачаар улсын төсвийн санхүүжилтээр мэргэшил дээшлүүлэх сургалтад тус оны 9 сард эмч нарыг хамруулахаар төлөвлөөд байна. 2022 оны хагас жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 1183 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 87 чиглэлээр ажлын байрны сургалтад хамрагдсан байна. 2022 оны төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр Бөөрний мэс засал судлал, эх барих эмэгтэйчүүдийн эхо, дурангийн онош зүй, жирэмсний хяналт, сэргээн засахын сувилахуй, хавдрын сувилахуй, хүүхдийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилахуй зэрэг 12 чиглэлээр анхан болон хоёрдогч шатлалын эмнэлгийн эмч сувилагч нар суралцаж, эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөц бэлтгэгдэж байна.</p>	
--	--	--	--	--	--	---	--

8		2.1.6. Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх		Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгаар дамжуулан 250-аас доошгүй иргэнд хүрч үйлчилсэн байна.	Жаргалтай амьдрал төвд 2022 оны эхний 5 сарын байдлаар 60 хүн 14 хоногийн хэвтүүлэн эмчлэх нөхөн сэргээх эмчилгээний хөтөлбөр, сумдаас 36 хүн өдрийн эмчилгээ, зөвлөгөөний хөтөлбөрт хамрагдаж, нийт 96 хүн үйлчлүүлсэн байна. Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний "Жаргалтай амьдрал" төвийн 2022 оны үйл ажиллагааны санхүүжилт 180.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжаар олгож, тогтмол зардал, эмч сувилагч, сэтгэл зүйчийн цалин, тусламж үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн, цаашид уг төвийн үйл ажиллагаа нь тасралтгүй хэвийн үргэлжлэх боломж нөхцөл бүрдээд байна.	50%
9		2.1.7. "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлэх		Анхан шатны нэгжүүдийн ёс зүйн багийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, чадавхжуулан, сургалт зохион байгуулна. Ёс зүй харилцаа	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор ЭМГ дээр өрөө гарган тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалаа. Хагас жилийн байдлаар	30%

				<p>хандлагын чиглэлээр үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагын сөрөг үзүүлэлтийг 2 хувиар бууруулна.</p>		<p>салбар хороонд 1 өргөдөл гомдол ирж шийдвэрлэсэн. Одоогоор эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын талаар үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа аваагүй байна, уг судалгааг энэ оны 8, 12 дугаар саруудад авч, нэгтгэн дүгнэж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулан ажиллана. Ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2022 оны 05 сарын 16-17-ны өдрүүдэд ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор "Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад эрүүл мэндийн салбарын 195 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагын сөрөг</p>	
--	--	--	--	--	--	--	--

						үзүүлэлтийг өмнөх жилтэй харьцуулан жилийн эцсийн байдлаар гаргана. Анхан шатны нэгжүүдийн ёс зүйн багийн үйл ажиллагаанд хагас жилээр үнэлгээ хийхээр төлөвлөөд байна.	
10		2.1.8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн хангалт 90-ээс дээш хувьд хүргэнэ.		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх ажил арга хэмжээний тендер 2 дахь удаагаа зарлагдаж, 5 аж ахуйн нэгж оролцож, тендерийн үнэлгээний хорооны үнэлгээ хийгдэж байна. Нэгдсэн эмнэлэгт “Эрүүл сэндийн дэмжих төв”-ийн 27 төрлийн 82 ширхэг 762.346.000 төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Үүнд: Спирометр, авторефактометр, ачаалалтай ЭКГ, тархины доплерын аппарат, чих хамар хоолойн иж бүрэн тоног төхөөрөмж, суурин эхо, ходоодны дуран, нүдний болорын хагалгааны аппарат зэрэг аппарат нийлүүлэгдсэн. ЭМС-ын дэмжлэгээр “Дэлхийн банк”-ны санхүүжилтээр 58.0	30%

						<p>сая төгрөгийн Mindray-Зөөврийн ЭХО аппаратаар хангагдсан. Төрийн нарийн бичгийн дарга асан Д.Очирбат 4 өрх, 20 сумын эрүүл мэндийн төвд 144.0 сая төгрөгийн Mark-B анализатор /BBB Inc/ аппарат хандивласан. Тоног төхөөрөмжийн хангалт өмнөх онд 85 хувьтай байсан бол 2022 оны хагас жилийн байдлаар 87 хувь болж, 2 хувиар нэмэгдсэн. Оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, иргэдэд хүргэх хүртээмж, чанар сайжирсан.</p>	
11		2.1.9. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын явцыг 80 хувьд хүргэх.		Амбулаторын барилгын явц 80 хувьд хүрсэн байна.		<p>Нэгдсэн эмнэлгийн 9.4 тэрбум төгрөгийн өртөгтэй амбулаторын барилга одоогийн байдлаар суурь бүрэн хийгдэж, 1 болон 2 дугаар давхрын каркас угсралтын ажил явагдаж, 30.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.000 гаруй хүн амд хоёрдогч шатлалын өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын</p>	30%

						шаардлагад нийцсэн орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэх юм.	
12		2.1.10. Заг, Галуут сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын тасгийн эмнэлгийн барилгыг засварлах		Заг, Галуут сумдын халдвартын тасгийн барилгын засварын ажил хийгдэж дууссан байна.		Заг сумын ЭМТ-ийн барилга ХАА-ны газраар тендер зарлуулсан боловч шаардлагад нийцсэн ААН шалгараагүй тул түр хугацаагаар хойшлогдсон. Галуут сумын ЭМТ-ийн барилгын засварын тендер үнэлгээний шатандаа явж байна. Заг сумын халдвартын тасаг стандартын бус нөхцөлд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа тул дээрх шаардлагад нийцүүлэн засвар үйлчилгээг явуулах юм. Галуутын эрүүл мэндийн төвийн халдвартын тасагт засвар үйлчилгээ хийгдсэнээр уг тасгаа түшиглэн ахмадын сэргээн засах төвийг байгуулж, өрөө тасалгааны хүртээмжээ сайжруулан, сэргээн засах эмчилгээг өргөжүүлэхээр ажиллаж байна.	30%
13		2.1.11. Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлэг барих		Оточ номгон эмнэлгийн барилгын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэсэн байна.		Аймгийн төвийн Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга худалдан авах ажиллагаагаар тендер зарлагдан, “Базардарь” ХХК	30%

						шалгарч, гэрээ байгуулсан. Тус өрхийн эмнэлэг баригдсанаар 7300 гаруй хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ээлтэй орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэж, аймагтаа өрөө тасалгаа хүртээмжтэй, стандартад нийцсэн жишиг өрхийн эмнэлгийг байгуулахаар ажиллаж байна.	
14	2.2. Идэвхитэй амьдрал – Чийрэг иргэн	2.2.1. Усан бассейн бүхий цогцолборыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах		Спорт цогцолбор хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр 100 хувь хангагдана.		Усан бассейн бүхий цогцолборын барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, дотор халаалтын систем, цахилгааны монтаж, заслын ажил хийгдэж байна. Биеийн тамир спортын улсын хороонд 63 төрлийн усан спортын хэрэглэл материалын судалгааг 252.3 сая, спорт заалны тоног төхөөрөмж-202.0 сая нийт 452.3 сая төгрөгийн санхүүжилтыг шийдвэрүүлэхээр хүргүүлсэн.	50%
15		2.2.2. Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлетикийн талбай байгуулах		Хөнгөн атлетикийн зориулалттай талбай бий болсон байна.		Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хөнгөн атлетикийн талбайг "Даяар трейд" ХХК 45 хувийн гүйцэтгэлтэй 2022 оны 07 сард ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Талбайг байгуулснаар хүүхэд	50%

						залуучуудыг стандартын зориулалтын зам талбайд бэлтгэл дасгалжуулалт хийж, улс аймаг бүсийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргах нөхцөл бүрдэнэ.	
16		2.2.3. Бадминтон, үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах		Бадминтон, үндэсний бөхийн спортын төрлийн хөгжлийг дэмжиж, улсын аварга шалгаруулах тэмцээн байгуулагдсан байна.		Бадминтоны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Баянхонгор аймагтаа амжилттай зохион байгуулагдаж, Тэмцээнд Архангай аймаг, Баянхонгор аймаг, Дархан-Уул, Дорнод аймаг, Орхон, Өмнөговь аймаг, Өвөрхангай аймаг, Хэнтий аймаг, Хөвсгөл аймаг, Налайх дүүрэг, Ёл клуб, Шталл клуб, Хан хиллс клуб 13 аймаг, дүүрэг, клубын 346 тамирчин оролцож, Биеийн тамир, спортын газар, "Хонгорын өглөө" Бадминтоны холбоо, Спортын төрөлжсөн Эрдэнэмандал сургууль хамтран зохион байгуулсан. Бадминтоны улс аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулснаар улсын хэмжээнд шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутагт	70%

						хөгжүүлж, аймаг орон нутагт 5 сумын 126 өсвөр үеийн хүүхэд залуучууд эхлэн хичээллэж байна. Үндэсний бөхийн Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 09-р сард зохион байгуулагдана.	
17		2.2.4. Спортын холбоодыг дэмжих		5-аас доошгүй спортын холбоодод дэмжлэг үзүүлсэн байна.		Спортын 21 холбоотой хамтран ажиллаж байна. Спортын холбоод нь аймаг бүс, улсын чанартай тэмцээнүүд болон Монголын бүх ард түмний спортын XV наадам, Монголын үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээнүүдийг хамтран зохион байгуулсан. Сагсан бөмбөгийн холбоо-аймгийн 2022 оны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах U18 өсвөр үе, насанд хүрэгчид, хангайн бүсийн тэмцээн, Волейболын холбоо-аймгийн 2022 оны волейболын аварга шалгаруулах U18 өсвөр үе, насанд хүрэгчдийн тэмцээн, Хөл бөмбөгийн холбоо-2022 оны аймаг, улсын аварга шалгаруулах тэмцээн, "Хонгорын өглөө" Бадминтоны холбоо-өсвөр үеийн 2022 оны аймаг, улсын аварга	50%

						шалгаруулах тэмцээн, Үндэсний бөхийн холбоо-аймгийн аварга шалгаруулах өсвөр үе, насан хүрэгчид, цолтой бөхчүүдийн барилдаан, Үндэсний сур, байт харвааны холбоо-2022 оны аймгийн аварга шалгаруулах байт сур, сурын харвааны тэмцээн, Шатрын холбоо-насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Даамны холбоо-насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Крикетийн холбоо-улсын аварга шалгаруулах тэмцээн, Софт волейболын холбоо-аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Жүдо, Чөлөөт бөхийн холбоо-аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Ширээний теннисний холбоо-аймгийн 2022 оны аварга шалгаруулах өсвөр үе, насанд хүрэгчид, хангайн бүсийн тэмцээнийг тус тус арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран зохион байгуулсан.	
18	2.2.5. Ламын гэгээний их тойром шагайн харваа зохион байгуулах			Ламын гэгээний их тойром шагайн харваа зохион байгуулагдсан		Шагайн харвааг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж 7 сард	30%

					байна.		зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн сумдын биеийн тамирын арга зүйчдэд шагайн харваанд оролцох харваачдыг бэлтгэл сургуулилтыг ханган ажиллах тухай чиглэл хүргүүлээд байна	
19		2.2.6. Шинэжинст сумд спорт заал барих			Спорт заалны барилга баригдаж дууссан байна.		Шинэжинст сумын спорт заалыг “Буян арвижих” ХХК-барилгын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.	50%
20		2.2.7. Дөвөнтийн заалны их засварыг хийх			Дөвөнтийн заалны их засварын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэсэн байна.		Багийн спорт заалыг “Буян арвижих” ХХК засварын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 40 хувьтай.	50%
21	2.3. Боловсролын чанар хөгжлийн тулгуур	2.3.1. Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн барилга барих			Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.		Баянхонгор сумын 1 дүгээр багт байрлах 2 дугаар цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж шинээр барих ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендерт 2 зарлагдсан тул Худалдаан авах ажиллагааны газраас өгсөн зөвлөмжийн дагуу “Шинэ өлгийн зам” ХХК шууд гэрээ байгуулсан. Одоогоор ажил эхлээгүй байгаа.	30%
22		2.3.2. Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгад их засвар			Цэцэрлэгийн насны 220 хүүхэд сургуулийн		“Жаргантайн хөх тариа” ХХК-тай шууд гэрээ байгуулсан,	30%

		хийх		өмнөх боловсролд хамрагдах таатай орчинг бүрдүүлнэ		одоогоор ажил эхлээгүй байна.	
23		2.3.3. Гурванбулаг сум, Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны сургуулийн хичээлийн байрны барилгыг барих		Гурванбулаг сумын сургуулийн 160 хүүхдийн хичээлийн байрны барилгыг ашиглалтад оруулж сурагчдын суралцах орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэнэ.		Гурванбулаг сумын сургуулийн барилгын суурийн ажил хийгдэж 1, 2 дугаар давхарын багана цутгалт хийгдсэн 2 давхарын дээврийн цутгалт хийгдсэн ажлын гүйцэтгэл 50 хувьтай "Гурванбулаг сод" ХХК яам дээр гэрээ шинэчлэгдэж байгаа ажил эхлээгүй байна. Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажлыг "Очиртзаан" ХХК хийж гүйцэтгэж байгаа суурийн ажил хийгдсэн ажил 15 хувьтай байна.	50%
24		2.3.4. Баянхонгор сумын 5-р сургуулийг цэвэр усны шугамд холбох		Сургуулийг цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангана.		Цэвэр усны төвлөрсөн шугамд холбох ажил эхлээгүй байна	0%
25		2.3.5. Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварыг хийх		Богд сумын 320 хүүхдийн суралцах орчин нөхцөлийг сайжруулна.		Сургуулийн гадна засварыг "Түйн долгио" ХХК гүйцэтгэхээр материалын татан авалт хийж, 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлыг 15 хоногт хийж гүйцэтгэх	50%

						төлөвлөгөөтэй байна. Гадна пассат хөөсөөр, үүдний хаалга шинээр хийнэ. Нийт төсөвт өртөг 75.5 сая төгрөг, 6 сард ажил эхлэхээр төлөвлөгдөж байна. /Төсөвт тусгагдаагүй ч цонхны тавцангийн хөмсөг төмрөөр хийж өгөхөөр болсон./	
26		2.3.6. Жаргалант сумын сургуулийн их засвар		Жаргалант сумын сургуулийн их засвар хийгдсэн байна.		Жаргалант сумын ЕБС-ийн гал тогоо, хүнсний агуулахын их засварын 120 сая төгрөгийн үнийн дүн бүхий тендерт Ерөөл нэмэх ХХК шалгарч, 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Засаг даргатай гэрээг байгуулсан байна. Аймгийн Барилга хот байгуулалтын газраас барилгын засварын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл хүссэн бөгөөд хариуг хүлээж байна. Засварын ажилд шаардагдах материал вакум цонх, хаалт, будаг, хар цагаан замаск татан авалт хийсэн.Сургуулийн хувьд ирэх 7 хоногийн эхээр сургуулийн гал тогоо, агуулахыг бүрэн суллаж өгөхөөр бэлтгэл ажлаа хангаж байна.	30%

27	2.3.7. Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийх		Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийгдсэн байна.		Баян-Овоо ЕБС-ийн Дотуур байрны их засварын ажлыг хийж гүйцэтгэхээр Есөн-Од ХХК-н сонгогдсон байна. Нийт 250,000,000 төгрөгний төсөвт өртөгтэй. Гүйцэтгэгч нь 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр эхлэн 2022 оны 08дугаар сарын 25-ны ашиглалтанд оруулахаар гэрээнд тусгасан байна.. Одоогоор хийгдэж эхлээгүй байна	50%
28	2.3.8. Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгын дээврийн их засварыг хийх		Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгын дээврийн их засварыг хийгдэж дууссан байна.		Сургуулийн дээврийн засварын ажил 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 15 хувьтай байна.	50%
29	2.3.9. Баянговь сумын цэцэрлэгт хүрээлэнг засварлах		Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлнэ.		Баянговь сумын цэцэрлэгт хүрээлэнг засварлах ажилд аймгийн ОНХСангаас 100 сая төгрөгний дэмжлэгийг үзүүлсэн.	50%
30	2.3.10. Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх		Нийт багш нарын 50 хувь /ЕБС-500 багш, СӨБ-100 багш/-ийг зөөврийн компьютероор хангах, 5 сургуульд контент боловсруулах лаборатори байгуулна.		Тоног төхөөрөмжийн тендэр шалгаруулах явцад маргаан гарч сангийн яам дээр хүлээгдэж байгаа.	30%

31		2.3.11. Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмж			Хоцрогдолд өртсөн сурагчдын сурах орчин нөхцөл сайжирч, сурлагын хоцрогдлыг бууруулна.	2021-2022 оны хичээлийн жилийн эхэнд сурлагын стандарт хангалт 41,6 хувьтай байсан хичээлийн жилийн эцэст буюу 2022 оны 05 дугаар сарын 23-27-нд БШУЯ, Боловсролын үнэлгээний төвөөс сурлагын стандартыг бүх анги, бүх хичээлээр нийт сурагчдын 50 хувийг хамруулан шалгалт хийгдсэн, үнэлгээ дүн гаргаагүй байна. Нийт 18000 гаруй сурагчдын 50 гаруй хувь малчдын хүүхэд байна. Зорилтот бүлгийн хүүхдийн сурах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр 9 сургуульд цахим танхим байгуулахаар 642 сая төргөний төсөвт өртэйгөөр байгуулахаар тендер зарлаж “Санко маркетинг mongoli ” ХХК шалгарсан,	30%
32		2.3.12. Сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого, орчны стандартыг хангах			Хүүхэд хамгааллын бодлого, орчны стандартын хэрэгжилтийг 60-аас дээш хувьд хүргэнэ	2022 оны “Хүүхэд хамаатай орчин хяналт шалгалт хийж, аюулгүй байдлыг хангуулах тухай” А/270 дугаар захирамжаар сургууль, цэцэрлэгийн дотуур байрны орчинд үнэлгээ хийхэд шалгуурыг бүрэн хангасан буюу бага эрсдэлтэй 34	0%

						<p>цэцэрлэг, дундаж эрсдэлтэй 9 цэцэрлэг, Сургуулиудаас орчны стандарт хангалт 0-30 хувь 2, 31-59 хувьтай 6, стандарт хангаж буй 60-89 хувьтай 18 сургууль, сайн хангасан 90-100 хувьтай 6 сургууль дотуур 6 сургууль дотуур байрны хувьд стандарт хангалт 0-30 хувь 3, 31-59 хувьтай 4, стандарт хангаж буй 60-89 хувьтай 11 дотуур байр, сайн хангасан 90-100 хувьтай 6 дотуур байр байгаа нь тус тус тогтогдлоо. Сургууль, цэцэрлэгийн 81,6 хувь нь стандарт хангаж байна. Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг батлан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлыг зохион байгуулж байна. Хүүхдийн эрх, үүргийг сургууль, цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах, хүүхэдтэй ажиллах аргазүй хандлагаа өөрчлөхөд багш, эцэг эхчүүдэд дэмжлэг</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>үзүүлэхэд чиглэсэн тасралтгүй тогтмол, үр дүнд хүрэхүйц ажил арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх зорилго бүхий “5X”-гийн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах улмаар танхимын хичээл хэвийн эхэлсэнтэй холбоотой багш, эцэг эхэд үүсэж байгаа айдас түгшүүрийг багасгах мэдээлэл зөвлөмж өгөх зорилгоор Баянхонгор сумын сургууль тус бүрээс 20 багш удирдах ажилтан, 20 эцэг эх цэцэрлэг тус бүрээс 10 багш , эцэг эхийн төлөөлөл нийт 405 хүн хамруулан үйл ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг дэмжих үндсэн хүчин зүйл нь багш сурагчийн эерэг уур амьсгал байдаг, тухайн орчныг дэмжих зорилгоор “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургагч багш бэлтгэх 2 дахь шатны сургалтыг сургалтын менежерүүдийг хамруулан зохион байгуулсан, мөн 3 дахь шатны сургалтыг сургагч багш нар хамтран ерөнхий</p>	
--	--	--	--	--	--	--	--

						боловсролын 28 сургуулийн хэмжээнд нийт багш, ажилтнуудыг хамруулан зохион байгууллаа.	
33		2.3.13. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх.		Гурванбулаг, Хүрээмарал, Богд сумын сургууль, цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.		Нэгдүгээр ээлжинд хийгдэх Бөмбөгөр сумын 320 хүүхдийн хичээлийн байр, 100 хүүхдийн цэцэрлэгийн байр, 50 хүүхдийн ортой дотуур байрны барилгад ариун цэврийн байгууламж 65 хувьтай, Заг сумын 160 хүүхдийн суудалтай хичээлийн байр, 75 хүүхдийн ортой цэцэрлэгийн байр, 80 хүүхдийн ортой дотуур байранд тавигдах ариун цэврийн байгууламж 75 хувьтай, Баянбулаг сумын 90 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ариун цэврийн байгууламж 50 хувьтай гүйцэтгэлтэй байна. Мөн Баян-Өндөр сумын сургууль, дотуур байранд тавигдах ариун цэврийн байгууламжийн ажил хийгдээгүй. Хоёрдугаар ээлжид хийгдэх Богд, Хүрээмарал, Гурванбулаг сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын ариун цэврийн байгууламжийн ажил хийгдээгүй байна.	

						Эдгээр сургууль цэцэрлэгийн арин цэврийн байгууламжтай болсноор хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна	
34		2.3.14. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах.		Галуут, Баянлиг, Бөмбөгөр, Жаргалант, Шинэжинст сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилнэ.		Баянхонгор сумын Эрдэнэмандал, Номгон ахлах сургуулиудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үдийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендэрт "Чиглэл" ХХК шалгарч Боловсрол, шинжлэх ухааны газартай гэрээ байгуулан ажиллаж тоног төхөөрөмжийг нийлүүлснээр дээрх сургуулиудын хоол үйлдвэрлэл стандартын дагуу болж сайжирлаа. Галуут, Баянлиг, Бөмбөгөр сумын хувьд 2021 оны жилийн эцсээр гал тогооны тоног төхөөрөмжөө шийдвэрлэсэн, Шинэжинст, Жаргалант сумын хувьд хараахан шийдээгүй байна	
35		2.3.15. Бага насны хүүхдийн цогц хөгжил хамтын ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх.		Салбар дундын уялдаа холбоог хангаж стратегийн төлөвлөгөөний биелэлтийг 55-аас дээш хувьд хүргэнэ.		Бага насны хүүхдийн цогц хөгжил-2022 ажлын төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 23 ажлыг төлөвлөн эхний хагас жилд хийх 12 ажил нь бүрэн хэрэгжиж дараах хүүхдэд эрүүл мэнд,	

						<p>боловсрол, хоол тэжээл, асаргаа хамгааллын мэдлэг чадвар олгох, гэр бүлдээ дадал болголоо. 2. Бөмбөгөр, Эрдэнэцогт сумдын цэцэрлэгийг түшиглэсэн цэцэрлэгт хүүхэд нь хамрагдаагүй эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Эцэг эх”-ийн клубыг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулан (14.3 сая төгрөг) 245 өрх гэр бүлд үйлчилгээ үзүүлж, Залуучуудын сонирхлын бүлэг, Эмээ өвөөгийн бүлэг, Жирэмсэн болон 2 хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн бүлэг, 3-5 насны хүүхэдтэй гэр бүлийн бүлэг гэсэн сонирхлын 5 бүлгийг санаачилгаараа үүсгэж, 115 эцэг эх нэгдэн үйл ажиллагаа явуулж эхлээд байна. 3. Бага насны хүүхдийн цогц хөгжил багийг 18 сумд байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн .4. Сургалт, сурталчилгаа: Бага насны хүүхдийн цогц хөгжил 6 төрлийн 13 зурагт хуудас, Гэрийн эзэгтэйн бага насны хүүхдэд зориулсан хоолны жор технологи, Бага насны</p>	
--	--	--	--	--	--	---	--

						хүүхдийн эрх-хамгаалал, Хүүхдийн хөгжилд таны оролцоо гарын авлагыг бэлтгэн цэцэрлэгүүдэд хүргүүлснээр цэцэрлэгийн багш нар болон эцэг эхчүүд хүүхдээ хөгжүүлэхэд зохих хувь нэмэр болсон	
36		2.3.16. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ.		Нийт багш нарын 40 хувийг чадавхжуулах сургалтад хамруулж багш нарын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж урамшуулна		Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй” сэдэвт сургалтыг цахим хэлбэрээр Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулахад 14 судлагдахууны 633 багш хамрагдан ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, зөвлөмжтэй танилцан шалгуурыг оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээнд хэрэглэх арга зүй, аргачлалд суралцлаа. Мэргэжлийн багш нарын сургалтад нийт 441 хамрагдаж сурагчдын агуулгын хоцрогдлыг нөхөж буй арга зүй туршлагаа хуваалцан, мэргэшлийн мэдлэг, ур чадвараа	

						<p>дээшлүүлээ. Хичээлийн цахим контентын сан бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Боловсролын мэдээллийн технологийн төв”-ийн дэргэдэх “Ээлжит хичээлийн цахим контент шалгаруулах зөвлөл”-ийн гишүүд “Ээлжит хичээл боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад бага, дунд ангийн 70 багш , Монгол улсын боловсролын их сургуулийн Багшийн сургуулийн сургалтын албанаас бага ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад 97 багш, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 2021-2022 оны хичээлийн жилд 4 дэх жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх орон нутгийн үндсэн сургалт онлайн хэлбэрээр зохион байгуулагдаж 68 багш мэргэжлээ дээшлүүлсэн нь сургалтын агуулга арга зүйн шинэчлэлт хийхэд чухал ач холбогдолтой боллоо. Давхардсан тоогоор цахимаар 701, танхимаар 618 багш харагдсан нь нийт багш нарын 51,5 хувь нь мэргэжил</p>	
--	--	--	--	--	--	--	--

						дээшлүүлсэн байна.	
37		2.3.17. Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргаж болзол хангасан багш сурагчдыг шагнаж урамшуулах		Амжилтаа бататгаж, багш сурагчийг шагнаж урамшуулна.		Хичээлийн жилд 750 гаруй сурагчид бүрэн дунд боловсрол эзэмшинэ. Төгсөж буй сурагчдын ЭЕШ-д бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах зорилгоор сорил шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Үүнд “Сорил-1” шалгалтыг 2-р сард зохион байгуулсан. Энэ шалгалтын дүнг бүх сурагчдын гарааны түвшин, үнэлгээ болгож авсан. “Сорил-2” шалгалтыг 3-р сард Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаярын нэрэмжит болгон зохион байгуулсан. Энэхүү шалгалтаар анхны оноо буюу гүйцэтгэлийн хувь нь “сорил-1”-ээс ахисан 107 сурагч, бэлтгэсэн сурагчдын гүйцэтгэлийн дундаж хувь нь ахисан 5 багшийг батламж, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Сургуулиудын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт 10 хичээлийн нийлбэрээр 8,4 хувиар өссөн. Ялангуяа бүх хичээлүүд дээр арифметик	

						дундаж, медиан өссөн нь гүйцэтгэл муу байсан масс хэсэг рүү анхаарал хандуулсны үр дүн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл өмнөх сорил шалгалтыг суурь түвшин болгож авахдаа гүйцэтгэлийн хувийг 4 завсарт хувааж, завсар тус бүр дэх сурагчид руу анхаарч чадсан байна. “Сорил-3” шалгалтыг 4-р сарын 30-д Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханы нэрэмжит болгон зохион байгуулсан.Элсэлтийн ерөнхий шалгалт 6 дугаар сарын 23-25 зохион байгуулагдаж эцсийн дүн гарна	
38		2.3.18. Төрийн албан хаагч, иргэдийн үндэсний бичгийн чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах		Төрийн албан хаагчдын монгол бичгийн түвшинг ахиулж хэрэглээнд сургах, монгол бичгийн орчин бий болгоно.		Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/83 захирамжийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг, Хэлний бодлогын салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар тус тус батлуулсан. Монгол хэлний хичээлээр ЭЕШ-д бэлтгэж буй багш, сурагчдад дэмжлэг болох, үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах зорилгоор “Би-	

						<p>Үндэсний бичигтэн” аяныг 6 бүлэг сэдвийн хүрээнд 12 удаагийн сорилыг авч, анализ хийн нэгтгэж байна. Сорил шалгалтад тогтмол 150-160 сурагч хамрагдаж байгаа. Монгол хэл, бичгийн багш нарын онолын мэдлэг, мэргэжил арга зүйн захиалгат сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг МУБИС-ийн Монгол Судлалын Сургуулийн багш, дэд профессор Д.Эрдэнэсан /Ph.D/ багш удирдан, лекц сургалтыг чанартай орсон. Сургалтад аймаг, сумын нийт 65 багш бүрэн хамрагдсан. Монгол бичгийн “Бийрийн бичлэг”-ийн сургалтыг уран бичээч багш Б.Арсай зохион байгуулсан. Сургалтыг 5 хоногийн хугацаанд 10 багш, 9 сурагчийг хамруулан сургасан билээ. Аймгийн “Тэргүүний уншигч” шалгаруулах үндэсний бичгийн хурдан уншлагын уралдаанд 14 сум, аймгийн ЕБС-аас шалгарсан нийт 114 сурагч оролцож, 2 ангилал тус бүрээс шалгарсан нийт 10 сурагчийг улсын уралдаанд оролцох эрх,</p>	
--	--	--	--	--	--	--	--

						Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Аймгийн Засаг даргаас 5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн	
39		2.3.19. Иргэдийн тасралтгүй боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх		Танхимын болон цахим контентоор 40000 гаруй иргэнд үйлчилнэ. 5 төрлийн контентыг гаргаж, 5-аас багагүй клуб, сонирхлын бүлгийг дэмжинэ.		Насан туршийн боловсролын төвөөс захиалгат сургалтын хөтөлбөрийг 5 агуулгын хүрээнд 50 сэдвээр гаргаж байгууллагуудаас захиалга авсан. 10 төрийн байгууллагын 250 албан хаагчдад 75 удаагийн сургалтаар 101 сэдвээр сургалт явууллаа. Нэмэлтээр Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид “Өрхийн төсөв, орлого ба зарлага” сэдэвт сургалт 79 алба хаагчдад явуулсан. Жинст сумын ерөнхий боловсролын сургуулийн НТБ-ын нэгжийн захиалгаар сумын ЗДТГ, сургуулийн захиргаатай хамтран 4-9 ангийн 137 сурагчдад Ажил мэргэжлийн чиг баримжаа”, 30 багш ажилчдад “Багшийн ёс зүйн дүрэм”, “Байгууллагын уур амьсгал”, 80 иргэдэд амьдрах ухааны сургалт тус тус явууллаа. Богд сумын ЗДТГ-ын захиалгаар 200 эрчүүдэд амьдрах ухааны сургалт, 8-11	

						<p>ангийн 138 сурагчдад “Ажил мэргэжлийн чиг баримжаа” сэдэвт сургалт тус тус явууллаа. НТБ-ын төв, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Цэвэр хот ОНӨААТҮГ хамтран “Хотын соёл” сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд СӨБ-ын 500 хүүхдэд “Сайн хүүхэд” сэдэвт сургалт, 1-12-р ангийн 800 сурагчдад “Хотын соёлд-Миний оролцоо” сэдэвт сургалт, 18-34 насны 500 иргэдэд “Хотын соёлд-Залуучуудын үүрэг оролцоо” сэдэвт сургалт явуулсан. “Хотын соёл энгийнээс эхэлнэ” уриатай 15 цуврал постер мэдээлэл, 10 шторк олон нийтийн цахимд байршуулсан. “Дэлхийн мөнгөний 7 хоног-2022” аянг НТБ-ын төв, Баянхонгор аймаг дахь Монгол банк, Дэлхийн зөн ОУБ, Арилжааны банкууд, ХГБХГ-тай хамтран зохион байгууллаа. Үүнд:- НТБ-ын нэгжүүдтэй хамтран 703 иргэд, 6-12-р ангийн 666 сурагчдад онлайн сургалт явагдсан.-“Санхүүгийн</p>	
--	--	--	--	--	--	---	--

						сахилга бат” сэдвээр подкаст, уулзалт ярилцлага, “Постерын уралдаан”, “10000 төгрөг” нэвтрүүлэг, “АХА” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, 1200 сурагч, иргэд хамрагдлаа.Эхний хагас жилийн байдлаар 52 хувьтай байна.	
40		2.3.20. "Өрхийн хөгжлийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлэх		Өрхийг хөгжүүлэх төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран боловсруулж 239 өрхийг хамруулна.		Аймгийн Засаг даргын 2022 оны 4 сарын 19-ний өдрийн “Өрхийн хөгжил цогц арга хэмжээг зохион байгуулах тухай” А/253 дугаар захирамж гарсан. Захирамжаар арга хэмжээний удирдамж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан. Хийгдэж байгаа ажлууд: - Хөдөөгийн 19 сумын баг бүрийн 2 өрх, аймгийн төвийн баг бүрийн 5 өрх, нийт 240 өрх сонгогдсон. -Орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсэгт өрх бүрд нөхцөл байдлын үнэлгээ хийх, түүнд үндэслэн өрх бүр дээр ажиллах төлөвлөгөөг боловсруулах чиглэлийг онлайнаар хүргэсэн. Төрийн 250 албан хаагчид оролцсон. - Сонгогдсон 240 өрхийн нөхцөл байдлын үнэлгээг үндсэн хэрэгцээ, чадавх	

						<p>боломж, гэр бүл нийгмийн харилцаа гэсэн 3 чиглэлийн дагуу 38 асуумжаар гаргасан - Үнэлгээнд суурилан өрх бүрийн хөгжлийн төлөвлөгөөг 4 зорилт 32 ажлын хүрээнд боловсруулаад байна Нийт 236 өрх хамрагдсан</p>	
41	2.4. Шинжлэх ухаан технологи, инноваци	2.4.1. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалт зохион байгуулах		Аж ахуй эрхлэлтийн сургалтад 150 иргэнийг хамруулж бизнесийн төсөл төлөвлөгөө боловсруулах мэдлэг олгоно.		<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 165 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулахаар бүртгэлийн сан үүсгэсэн. "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих" хөтөлбөр болон "Хөгжлийн бэрхшээл иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн "Санхүүгийн дэмжлэг" арга хэмжээнд төсөл ирүүлсэн 95 иргэнийг зээлийн өмнөх сургалтад хамрууллаа. Сургалтын үр дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд бизнесээ амжилттай эрхлэх ур чадвар эзэмшиж, чадамжийн гэрчилгээ авлаа. Дэлхийн банкны санхүүжилттэй "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр" -ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг</p>	

						зээлд хамрагдах хүсэлт өгсөн 19 бичил бизнес эрхлэгчдэд Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл сургалтыг зохион байгуулж ажиллалаа.	
42		2.5.1. Гарааны бизнес эрхлэгч залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх			"Start-up" арга хэмжээнд хамрагдсан залуусын дунд уралдаан зохион байгуулж, шилдэг төсөлд дэмжлэг үзүүлнэ	Тус арга хэмжээг 2022 оны 3-4 улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.	
43	2.5. Халамжаас - Хөдөлмөрт	2.5.2. Ахмад настан, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих			Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өрх толгойлсон эцэг, эхчүүд, 40-өөс дээш насныхан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 130-аас доошгүй иргэнийг хөдөлмөр эрхлэлтээр дэмжинэ	Зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох төслийг олон нийтэд зарлаж, төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 81 төсөл, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 60 төсөл нийт 141 төсөл хүлээн авсан. Сонгон шалгаруулалтын шатанд явагдаж байна.	

44	2.5.3. “Хүмүүнлэгийн ордон”-ы тохижилт, үйлчилгээг сайжруулах (үйл ажиллагааны зардал)			Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангаж, эрүүл мэнд, сэтгэл засал, боловсрол, нийгмийн суурь үйлчилгээнүүдэд хамрагдах таатай орчныг бүрдүүлнэ.		Хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэнийг байнгын ажлын байраар хангах, ажиллах орчныг сайжруулах, нийгмийн суурь үйлчилгээг үзүүлэх зорилгоор 7 өрөөг ашиглалтад оруулж таатай орчныг бүрдүүлсэн.	
45	2.5.4. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих			Аймгийн бүтээн байгуулалтын ажилд 500-аас доошгүй иргэдийг хамруулна.		Аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын ажилд 455 /мод тарих ажилд 435 хүн, нийтийг хамарсан ажилд 20 хүн/ иргэнийг ажиллуулж, түр ажлын байраар ханган 59.948.000 төгрөгийн урамшуулал олгосон	
46	2.5.5. Хүнсний эрхийн бичигт хамрагдсан иргэдэд хяналт мониторинг хийж хөдөлмөрт бэлтгэх			Хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийн 20-оос доошгүй хувийг байнгын болон түр ажлын байраар хангана		Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 831 өрхөд дотоод хяналтыг хийж журмын дагуу 8 өрхийн 43 гишүүн иргэнийг ХЭБ-ийн үйлчилгээнээс хассан. ХЭБ-ийн үйлчилгээ авч байгаа иргэдээс Хөдөлмөрийн насны 934 иргэн байна. Хөдөлмөр эрхлэх боломжтой 934 иргэдийн 20-оос доошгүй хувь буюу 186 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангахаас ХЭБ-ийн үйлчилгээ авдаг 449 иргэнийг /өссөн	

						дүнгээр/ түр ажлын байраар хангасан.	
47		2.5.6. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, ажил хайж буй залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг зохион байгуулах			Ерөнхий боловсролын ахлах ангийн 1800 хүүхэд, ажил хайж буй 750 залуучуудыг хамруулна	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 482, бүлгийн хэлбэрээр 202 иргэнд нийт 684 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан. ЕБС-ийн сургуулийн сурагчдад 3, 4 улиралд “Мэргэжлээ зөв сонгох нь” сургалтыг Алтан алхам ТББ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөн гэрээ байгуулан ажиллаж байна	
48		2.5.7. Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.			Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 280 иргэдийг, сайн дурын даатгалд шинээр хамруулна	Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 3927 иргэн /үүнээс малчин 2951 иргэн/ хамрагдаж 1,118.8 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 759.9 мянган төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж төлөвлөгөө 68% тай биелсэн. 2022 оны хагас жилийн байдлаар шинээр 160 иргэн нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдаж, урд оны мөн үетэй харьцуулахад 219 хүнээр бага хамрагдсан	

						<p>үзүүлэлттэй байна. Энэ нь 2020-2021 онд хэрэгжсэн нөхөн тооцох тухай хууль хэрэгжсэн, төрүүлсэн 1 хүүхдийн тоогоор ажилласан жилийг 1 жил 6 сараар тооцон нэмэгдүүлсэн, мөн ковидоос шалтгаалж эдийн засгийн хямралд орсон зэргээс шалтгаалж байна. Эрүүл мэндийн даатгалд оюутан-199 даатгуулагч иргэн, малчин-2100 даатгуулагч иргэн, ХХЭИ, АХЭИ-1290 даатгуулагч иргэн, нийт 3589 иргэн хамрагдаж, 221.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 199.9 сая төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 90,00 хувьтай байна.</p>	
49	2.5.8. Коллеж төгсөгчдийг ажлын байраар хангах замаар Бизнес инкубаторын үйлчилгээг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх			Коллеж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, төгсөгчдийн 80%-ийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна.		2022 оны хагас жилийн байдлаар коллеж төгссөн 221 төгсөгчөөс 74 төгсөгч буюу 33,5 хувь нь байнгын болон түр ажлын байранд зуучлагдсан байна.	
50	2.5.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн			Салбар зөвлөл, комиссын үйл ажиллагаа эрчимжиж төлөвлөгөө 85-аас дээш хувьтай хэрэгжиж		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлт 30 хувьтай, Хөгжлийн	

		хамгааллын салбар комисс", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих		зорилтот бүлгийн хөгжил, оролцоо дээшилнэ.		бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлт /шинээр асаргааны тэтгэмжид 12 хүүхэд, асаргааны тэтгэмжийн сунгалт 69 хүүхэд, асаргааны тэтгэмж шаардлагагүй 21 хүүхдийг бусад нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжтой талаар зөвлөгөө өгч ажилласан ба "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжүүлэх төв"-ийн өдрийн үйлчилгээнд 2 хүүхэд, ердийн цэцэрлэгт 14 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 28 хүүхэд, тусгай цэцэрлэгт 10 хүүхэд, нөхөн сэргээх эмчилгээнд 25 хүүхдийг хамруулсан/ 70 хувьтай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн төлөвлөгөөний биелэлт 60 хувьтай байна. Салбар зөвлөл, комиссоос 12 удаагийн хурал, үйл ажиллагааны хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн оролцоо, идэвх нэмэгдсэн.	
51	2.6. Соёлтой иргэн-	2.6.1. Соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр		СУИС-ийн өдөр, оройн анги, богино хугацааны		Соёлын салбарын боловсон хүчин нэмэгдүүлэх чиглэлээр	

	Нийгмийг түүчээлнэ	хангах, сургах			сургалтаар 20-оос доошгүй мэргэжилтнийг хамруулна.		МУБИС, СУИС-тай хамтран орон нутгийн "онлайн" эчнээ сургалтыг зохин байгууллаа. Сургалтад 8 иргэн хамрагдаж хөгжмийн багшийн бакалаврын зэрэгтэй төгссөн. Орон нутагтаа мэргэжлийн боловсон хүчний хангалтыг тодорхой хувиар нэмэгдүүлэх зорилгоор СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн захирал Ж. Ганхуягтай хамтран ажиллах хамтын ажиллагааны санамж бичгийг байгууллаа. Соёлын байгууллагуудын дарга захирал нартай хамтран ажиллах гэрээ болон 2022 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3,4 дэх заалтад Соёл, урлагийн сургуулийн эчнээ ангид 1-ээс доошгүй, өдрийн ангид 1-доошгүй иргэнийг сургах байх чиглэлийг өглөө.	
52		2.6.2. Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадам зохион байгуулах			Монголын зохиолчдын эвлэлийг үүсгэн байгуулагч, МУ-ын төрийн соёрхолт, зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнг алдаршуулах, утга зохиолын хөгжлийг		Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадамд зарцуулагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэж удирдамжийг боловсруулан товлот хугацаанд зохион байгуулхаар	

				хурдасгахад дэмжлэг болно.		хүлээгдэж байна.	
53		2.6.3. Иргэн Б.Дашгомбын бүтээсэн "Чингис хааны хөрөг"-ийг Түүх угсаатны зүй-Байгалийн музейн үзмэрт худалдан авах		Өв соёлын үнэт үзмэрийг олон нийтэд таниулан сурталчлах хүрээ өргөжнө.		Баянхонгор аймгийн чөлөөт уран бүтээлч, ахмад багш Хүрээмарал сумын уугуул Б.Дашгомбо-ын "Чингис хаан" утсан наамал бүтээлийг 18 сая төгрөгөөр музейн сан хөмрөгт худалдан авч сан хөмргийн баяжилт хийгдсэн.	
54		2.6.4. Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх, зарим нэг зүйлсийг хамгаалалтад авах		Өв соёлын үнэт үзмэрүүд хамгаалагдах аюулгүй орчин нөхцөл бүрдэнэ.		Түүх угсаатны зүй байгалийн музейнд дохиолол хамгаалалт суурилуулах, гэрэлтүүлгийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжилтийг шийдвэрлэн "Сүлжээний хөтөч ХХК" -ыг сонгож гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.	
55		2.6.5. Хүүхдийн Тэмүжин театрыг үзэгчдийн сандал, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах		Үйлчлүүлэгчдэд соёл, үзвэрийн тав тухтай, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.		Хүүхдийн Тэмүжин театрын гэрэлтүүлэг тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хэсэг, шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэн тус ажлыг зохион байгуулж СИТИ ЛЕД ХХК -тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж	

						үйлчлүүлэгчийн болон уран бүтээл туурвих орчин нөхцөлийг бүрдүүлсэн.	
56		2.6.6. Аймгийн Хөгжимт драмын театрт их засвар хийх			Театрын өнгө үзэмж сайжирч уран бүтээлчид, үйлчлүүлэгчдэд ая тухтай орчныг бүрдүүлнэ	үр дүнгүй	
57		2.6.7. Эрдэнэмандал хайрханы бурханы засвар, тохижилтын ажлыг хийх			Эрдэнэмандал хайрханы хөшөө, дурсгалын өнгө үзэмж сайжирна.	үр дүнгүй	
58		2.6.8. Бөмбөгөр сумд Гэрэлт хөшөө байгуулах			Түүх, соёл уламжлалаа сурталчилж хойч үе, олон нийтэд таниулна.	Бөмбөгөр суманд гэрэлт хөшөө босгох ажлын шав тавигдсан.	
59	2.7. Хонгорын иргэн-Хонгорын баялаг	2.7.1. Залуу малчин гэр бүлд "Хамтдаа шийдье" төслийг хэрэгжүүлэх			17 сумын 3000-аас доошгүй өрхөд хүрч зөвлөн туслах, сургалт, нөлөөллийн ажил үйлчилгээг үзүүлж хүүхэд хамгааллын талаарх мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна	"Хамтдаа шийдье" төслийн хүрээнд 11 сумын 2445 өрхөд сургалт зохион байгуулсан. ГБХЗХГ-ын сургагч багш нар сумдад ажиллан орон нутгийн хамтарсан багийн гишүүн 66 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн. Сургалтыг хүүхэд хүмүүжлийн эерэг арга, бага насны хүүхдийн цогц хөгжил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь, архины хор уршгийн талаарх агуулгын хүрээнд айл өрх бүрийн хаалгаар орж зохион	

						байгуулсан.6 сард Гурванбулаг, Заг, Жаргалант, Эрдэнэцогт сумдад ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
60		2.7.2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийг чадавхжуулах /оролцоо/		Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг сайжруулна		Жендэрийн салбар хороо, дэд салбар хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулсан.Төрийн хэмнэлтийн тухай хуулиар түр хойшлогдсон.Сумдын дэд салбар хорооны дарга, мэргэжилтэнүүдийг 1 удаагийн цахим сургалтад хамруулсан.	
61		2.7.3. "Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх		Төслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ		Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Жендэрийн салбар хороо, аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, БШУГ, “Хонгор нутгийн үрс” ТББ, “Талын сарнай” ТББ-ын сургагч багш нар хамтран “Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг чадвар олгох” сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.Сургалтад	

						Баянхонгор сумын 6 цэцэрлэгийн багш, эрхлэгч, ГБХЗХГ, Цагдаагийн газрын сэтгэл зүйч, БШУГ-ын мэргэжилтэн зэрэг 15 хүн хамрагдаж хүний эрх болон хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, төрөл, хүүхдэд үзүүлэх хор нөлөө, уршгийн талаарх суурь ойлголтоо бататган тэлж, бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга техникт суралцан, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх ур чадвар эзэмшиж сургалтыг түгээн дэлгэрүүлж байна.Орон нутгийн онцлогт тохирсон сургалтын модулыг боловсруулж байна.Тайлан нэгтгэгдэх хугацаа болоогүй.	
62		2.7.4. "Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийн засаглал, хамгааллын зорилтыг хэрэгжүүлэх		Судлаач хүүхдүүдийг чадавхжуулан зорилтот 3-аас дээш бүлэгт судалгаа хийж шийдвэр гаргагчдыг мэдээллээр ханган орон нутгийн бодлого шийдвэрт хүүхдийн бодит оролцоог бий болгоно. Хүүхдийн Экспог зохион байгуулж 100-		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг 2 удаа хуралдсан.2021 оны тайланг нэгтгэж НҮБ-ын Хүүхдийн санд хугацаанд нь хүргүүлсэн.Аймгийн Засаг даргын А/265 тоот захирамжаар “Хүүхдэд ээлтэй орон нутаг” санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025	

				аас доошгүй хүүхдийг хамруулж алдаршуулна. "SASA" активистуудыг хөгжүүлэх, дэмжих стратегийг 80-аас дээш хувьтай хэрэгжүүлнэ		оны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
63		2.7.5. Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийг тоног төхөөрөмжөөр хангах		Орон нутгийн эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн төслийг хэрэгжүүлнэ.		Тоног төхөөрөмж нийлүүлэх тендэр зарлагдаж Саммит компани шалгаран гэрээ байгуулсан.6-р сард нийлүүлэгдэх бэлтгэл ажлыг хангаж байна.	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
64	3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна.	3.1.1. Татварын хууль эрх зүйн актуудын шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх болон цахимаар татвар, төлбөр, хураамжаа төлөх хандлагыг төлөвшүүлэх, татварын бааз суурийн бүртгэл мэдээллийг сайжруулах замаар төсвийн орлогыг 2021 оны суурь төвшнөөс 45%-иар нэмэгдүүлэх		Аймгийн Татварын болон татварын бус орлогын хэмжээг 16.3 тэрбум төгрөгөөс давуулан биелүүлэх		Татварын хэлтэс нь 2022 онд улс, орон нутгийн төсөвт 19.8 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар /05-р сарын орлогын мэдээ 06.05-нд гарна /өссөн дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэх 886,460.3 мянган төгрөгийн төлөвлөгөөнөөс 1,295,989.9 мянган төгрөг төвлөрүүлж 146.2 хувийн биелэлттэй буюу 409,529.6 мянган төгрөгөөр давуулсан бол орон нутгийн төсвийн татварын орлогоор 4,913,552.7 мянган төгрөг	

						<p>төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 4,174,580.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, 85 хувийн биелэлттэй буюу 738,972.7 мянган төгрөгөөр тасалсан байна. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогоор 2022 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 5,800,013.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5,470,569.9 мянган төгрөг төвлөрүүлж, 94.3 хувийн биелэлттэй буюу 329,443,1 мянган төгрөгөөр тасалсан байна. Татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран 2022 оны 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/02 тоот албан даалгавар гаргаж, сумдын Засаг дарга, татварын улсын байцаагч нарт хүргүүлж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг цахим төлбөрийн баримт олгодоггүй бизнес эрхлэгч, цахим худалдаагаар бараа, бүтээгдэхүүн борлуулагч этгээдийг</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>бүртгэлжүүлэх, цахим төлбөрийн баримт олгуулж, хэвшүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэлтсийн зохион байгуулалтын 4 тасагт томоохон зах худалдааны төвүүдийг хуваарилан өгч, төлбөрийн баримт хэвлэлтийг сард 10 хувиар нэмэгдүүлэхээр мэдэгдэл, шаардлага хүргүүлэн ажиллаж байна. Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үйл ажиллагааны орлого бүхий хувь хүн, үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн бүртгэл, мэдээллийг шинэчилж, үл хөдлөх хөрөнгийг татварын зорилгоор дахин үнэлэх ажлыг зохион байгуулж байна. Цахимаар татвар, төлбөр, хураамжаа төлөх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор и-баримтын буцаан олголтоос хөрөнгийн татварыг төлөх боломжтой талаарх сурталчилгааг татвар төлөгчдөд хүргэж, татвар төлүүлж ажиллав.</p>	
65	3.1.2. Санхүүгийн эрсдэл бүхий 2 байгууллагад дотоод аудит, 2 суманд Аймгийн Засаг даргын			Төсөвт байгууллагын санхүүгийн эрсдлийг бууруулж 23%-д хүргэж,	Засаг даргын 2022 оны А/139, А/221 дүгээр захирамжаар "Аймгийн Засаг даргын		

		нэрэмжит зөвлөн туслах ажлыг зохион байгуулах		төсвийн үр ашгийг дээшлүүлнэ.		нэрэмжилт нэрэмжит санхүүгийн хяналт шалгалтын ажлын хэсэг ажиллаж зөрчил дутагдлыг бууруулах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн ажилчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зөвлөмж хүргүүлсэн.	
66		3.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллого явуулах		Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжирсан байна.		Аймгийн Засаг даргын 2022 оны А/247 дугаар захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах комисс томилж, төлөвлөгөө, удирдамжийг батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
67		3.1.4. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, төрийн мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрүүд, түүний хэрэгжилтийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр мэдээллэх, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа хийх		Аймгийн төвийн болон хөдөө сумдын 500 иргэнд санхүүгийн мэдлэг олгосон байна.		Төрөөс 2022 онд мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд орон нутагт аймгийн Номгон телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж. Төрийн мөнгөний бодлогын шийдвэр, хэрэгжилтийг олон нийтэд хүргэн ажиллаж байгаа. Мөн БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНК фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан иргэдийн санхүүгийн боловсролыг	

						нэмэгдүүлэх, төрийн мөнгөний бодлогын шийдвэрийг иргэдэд таниулхаар видео контент, постеруудыг тогтмол түгээсээр байна. 2022 оны эхний 5 сарын байдлаар 72 мэдээллийг давхардсан тоогоор 25,974 хүн уншсан байна.	
68		3.1.5. “Бид ирээдүйн татвар төлөгч” арга хэмжээг Баянхонгор аймгийн ЕБС-ийн хүүхэд багачуудын дунд зохион байгуулах		ЕБС-ийн 10 сургуулийн сурагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлж татварын үнэ цэнийг таниулна.		Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад татварын талаар ойлголт мэдлэг өгөх зорилгоор аймгийн төвийн 4 сургуулийн 250 сурагчдад Татварын хэлтсээс бэлтгэсэн "Татвар гэж юу вэ", "Татвар бидний амьдралд" хичээлийг татварын улсын байцаагч нар хүүхдүүдэд танилцуулж, мэдээллийг хүргэлээ. Баянхонгор аймгийн Татварын хэлтэс facebook группт "Татвар бидний амьдралд" ЕБС-ийн сурагчдад зориулсан 4 хичээлийн контент байршуулж, олон нийтэд сурталчиллаа. Контентуудыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ЕБС-ийн сургуулиудад CD-нд буулган хүргүүлсэн. 2022 оны 04 дүгээр сард ерөнхий	

						<p>боловсролын сургуулийн сурагчдын дунд "Миний мэдэх татвар" гар зургийн уралдааныг зохион байгуулсан бөгөөд "Тэргүүн байр"-т Бууцагаан сумын ЕБС-ийн 8б ангийн сурагч Г.Удвалцэцэг, "Дэд байр"-т Эрдэм ахлах сургуулийн 12 а ангийн сурагч Б.Марал, "Гуравдугаар байр"-т Номундалай цогцолбор сургуулийн 2е ангийн сурагч Л.Амин-Эрдэнэ нарын бүтээл тус тус шалгарсан. Мөн Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Баянхонгор дахь салбартай хамтран "ОЙН НАЙЗУУД БА ТАТВАР"-богино хэмжээний контент бэлтгэх уралдааныг ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан бөгөөд уралдаанд нийт 6 бүтээл ирсэн. Уралдааны "Тэргүүн байр"-т Номундалай цогцолбор сургуулийн Г.Янжинлхам багштай 2е анги, "Дэд байр"-т Гурванбулаг сумын ЕБС-ийн Ц.Гомбосүрэн багштай сурагчид, "Гуравдугаар байр"-нд Эрдэнэмандал ахлах</p>	
--	--	--	--	--	--	---	--

						сургуулийн Д.Цагаан багштай 4а ангийн сурагчдын бүтээл тус тус шалгарлаа. ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд багачуудад Өргөмжлөл, мөнгөн шагнал олгож урамшууллаа. Тэмцээн уралдаанд оролцсон бүх хүүхдүүдэд Талархал гардуулж, өнгийн харандаа болон "ТАЗИ зөгийн адал явдал" татварын талаар ойлголт мэдээлэл өгөх номыг гардууллаа. Цаашид 2022 оны 3, 4 дүгээр улиралд сумдын ЕБС-ийн сурагчдад татварын талаарх ойлголт мэдлэг олгох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	
69		3.1.6. Сумдын санхүүгийн албаны 20 нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх		Төрийн сангийн нэгжүүдийн төлбөр тооцоо, төлбөрийн баримтын архив 100 хувь цахим тогтолцоонд шилжиж, компьютер техник хэрэгслийг бүрэн шинэчлэсэн байна.		Сумдын санхүүгийн албаны 20 нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын сонгон шалгаруулалтыг зарлаж, Айети юнипикэшн ХХК-тай шууд гэрээг байгуулан ажиллаж байна.	

	<p>3.2. Өрсөлдөх 70 чадвартай брэнд бүтээгдэхүүн</p>	<p>3.2.1. Хүн амын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэх</p>		<p>Хүн амын хаврын улирлын махны нөөцийг 200,0 тн-оор бүрдүүлж, хөнгөлттэй үнээр худалдан борлуулж үнийн хөөрөгдлөөс сэргийлнэ.</p>	<p>Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 160тн, "Баянжаргант хүнс" ХХК-тай 40тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгжүүд Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр, зоорьноос гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалж байна. Явцын хяналтыг Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамж батлуулан хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8000, үхэр /1кг/ 10000 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж байгаа нь зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштай байна. 2022 оны 04 дүгээр сарын 10-аас 06 дугаар сарын сарын 10 хүртэл худалдаална. Гэрээний</p>	
--	--	--	--	---	--	--

						гүйцэтгэлээр нийт санхүүжилтын 50 хувь буюу "Баянхонгор констракшн" ХХК-нд 40.0 сая, "Баянжаргант хүнс" ХХК-нд 10.0 сая төгрөгийг олгосон. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж үлдэгдэл санхүүжилт хийгдэнэ.	
71		3.2.2. Аймгийн мэргэжлийн холбоодуудын үйл ажиллагааг дэмжих /Оёдолчид, тогоочид, үсчид, гуталчид, бусад/		Мэргэжлийн холбоо 2-ыг шинээр байгуулж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулсан байна.		Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн холбоодыг чадавхжуулах, үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд гуталчдын холбоо, хүнсчдийн холбоодын 40 гаруй төлөөллийг 2022 оны 04 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо туршлага судлууллаа. Туршлага судлах аяллын хүрээнд Гуталчид гутал үйлдвэрлэлийн түүхий эд арьс шир боловсруулах, арьс, ширний лаборатори, гутлын түүхий эд материалын үйлдвэр "Мон ирээдүй ХХК", "Лугати ХХК", "Дархан минж ХХК", гутлын хими цэвэрлэгээний "Си Эс Эл ХХК" /Shoes love/-тай, хүнсчид "Траст трейд ХХК", гялгар уут, сав баглаа боодлын "Об	

						<p>пластик ХХК”, хүнсний салбарын тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэдэг “Технологийн дээд сургууль”-аар тус тус зочлов. Туршлага судлах аялалд хамрагдсан Салбар бүрийн төлөөлөл өөрийн мэдлэг мэдээллээ дээшлүүлж, хамтын ажиллагаагаа тэлж, орон нутагт шинэ техник технологи нэвтрүүлж ажиллах юм. Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад ажиллаж буй мэргэжлийн тогооч нарын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, орон нутгийн онцлогтой брэнд хоол, ундааг шалгаруулах, харилцан туршлага солилцох үүднээс 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ-2022” шалгаруулах уралдааныг зохион байгуулж, салбарын нийт 45 гаруй тогооч, оюутан нар өрсөлдсөн. Түүнчлэн Баянхонгор аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойд зориулж урчууд, уран бүтээлчдийг дэмжих, аймаг орон нутгийнхаа онцлог шинж чанарыг харуулсан,</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц загвар дизайн, сав баглаа боодолтой бэлэг дурсгал, гар урлалын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох зорилгоор “БАЯНХОНГОРЫН ОНЦЛОГТОЙ ГАР УРЛАЛЫН ХӨГЖИЛ” анхдугаар зөвлөгөөнийг 05 дугаар сарын 01-нд Гар урчуудын холбоотой хамтран зохион байгуулсан. Төв, хангайн бүсийн үсчин, гоо засалчдын уралдааныг 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар аймгийн үсчдийн холбоотой хамтран ажиллаж байна. Зөвлөгөөний хүрээнд 10 гар урчдад нийт 50,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс олгохоор болов.</p>	
72		3.2.3. Ингэний сүүний үйлдвэр, Мах, ногооны зоорь, Ногоон шим төслийг хэрэгжүүлэх		Ингэний сүүний үйлдвэр, Мах, ногооны зоорь, Ногоон шим төслийн үйл ажиллагааг эхлүүлнэ.		<p>Хөдөө аж ахуйн кластер байгуулах ажлыг 2021 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь"ХХК ажиллаж барилгын ажил 20 хувьтай байна. Ингэний сүүний</p>	

						<p>үйлдвэрийн нийт санхүүжилт 3.8 тэрбум бөгөөд 2021-2022 онд 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Мах ногооны зоорь барих ажлын гүйцэтгэгчээр "Сант Өндөр" ХХК ажиллаж барилгын ажлын явц 30 хувьтай байна. Тус ажлын нийт санхүүжилт 3.1 тэрбум бөгөөд 2021 онд 250 сая төгрөг олгосон. 2022 онд 950,0 сая төгрөгийн санхүүжилтыг гүйцэтгэлээр олгоно.</p>
73		<p>3.2.4. Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээл дэд төслийн ажлыг эхлүүлэх</p>		<p>Баялаг бүтээгч-Баянхонгор хөтөлбөрийн хүрээнд газар тариалан, Хөдөө аж ахуйн кластерийг хэрэгжүүлэх</p>		<p>Тус ажлыг 7 багцад хуваан тендер зарласан бөгөөд гүйцэтгэгчээр багц1-Хөдөө аж ахуйн Кластерийн барилга байгууламж -Татах хүч 3.315.066.3 багц2-Гүн өрмийн худаг, хашаажуулалт- гэрээ байгуулагдах шатандаа багц3-Баянлиг сумын тариалангийн талбайн цахилгааны станц, дэд станц-Гарьдсистемс багц4-Хөдөө аж ахуй машин тоног төхөөрөмж, багаж-Эм Эн Юу 2.835.200.0 багц5-Хөдөө аж ахуйн кластерийн гадна тохижилт, хүрмэн бетон хашаа-Гичгэнэхяр 1.173.962.5 багц6- 10x40 өвлийн 5 ширхэг хүлэмжийн барилга-</p>

						Биаконэроконстракшн 1.829.713.6 компаниуд шалгарч ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	
74		3.2.5. Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлэх			Шинэ хөдөө төслийг эхлүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийн хүрээнд мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн зориулалттай тусгай үйлчилгээний автомашины худалдан авах ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт зарлаж, гүйцэтгэгчээр "Улаанбаатар ариутгал" ХХК шалгарч гэрээ байгуулаад байна.	
75		3.2.6. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж				Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Баянхонгор, Баянлиг, Баацагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Заг/ нийлүүлэх сонгон шалгаруулалтыг зарлаж "Батбилэг Гурван Эрдэнэ" ХХК шалгарч гэрээ байгуулаж ажиллаж байна. Тус ажилд 11 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэх юм. Улсын	

						төсвөөс 450 сая төгрөгийн төсөвтэй.	
76		3.2.7. Үзэсгэлэн худалдаа гаргах зориулалтын /асар/ талбай байгуулж, Жижиг дунд үйлдвэрлэл, Мал аж ахуй, Газар тариалан эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах сувгийг нээж, орлого нэмэгдүүлэх.		20-оос дээш иргэн, аж ахуй нэгж оролцох багтаамжтай 4-н улирлын талбайд байршуулах 20 асар майхан худалдан авч, жилд 2-оос доошгүй үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэнээр орлого нэмэгдсэн байна.		Үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ая тухтай үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болгож асар майхан худалдан авахаар үнийн болон аж ахуй нэгжийн судалгааг хийсэн. Худалдан авах хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй.	
77	3.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс	3.3.1. Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх		Сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулан салбарын боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх эхлэлийг тавьж хэрэгжүүлнэ. /21 хүн/		Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлж байна. 2021-2022 оны хизээлийн жилд агрономич 1, малын их эмч 2, мал зүйч буюу зоотехникчээр 16 оюутан нийт 12 оюутан суралцахаар гэрээ байгуулан сургалтын төлбөрт нийт 27,2 сая	

						төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлээд байна.	
78		3.3.2. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, уст цэгийн хайгуул хийх		Гүн өрмийн 4 худаг шинээр гаргах буюу сэргээн засварлан, 20 цэгт уст цэгийн хайгуул хийж 30 мянган га талбайг усжуулж бэлчээр ашиглалтыг сайжруулна.		Энэ онд улсын төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-овоо, Өлзийт, Баянбулаг, Баян-Өндөр, Богд сумдад, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 150,0 сая төгрөгийн хөрөнгөөр Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Эрдэнэцогт, Жинст сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахаар гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажлын явц 30%-тай, 11 сард бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Сумын орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баацагаан 120,0 сая, Баянлиг 100,0 сая, Богд 23,5 сая, Бууцагаан 60,0 сая, Заг 20,0 сая төгрөгөөр инженерийн хийцтэй худаг гаргахаар, Баянговь 4, Богд 3, Өлзийт 2, Шинэжинст 3 цэгт тус уст цэгийн хайгуул хийхээр төлөвлөгдөн тендер сонгон шалгаруулалтыг зарлаад байна.	

79		3.3.3. Сарлаг болон бог малын хээлтүүлэгчдэд үзлэг, ангилалт хийх /Баянцагаан болон бусад сум/		20 сумын 13818 бог малын хээлтүүлэгчийг үзлэг, ангилалтад хамруулж цөм сүргийн тоог нэмэгдүүлнэ.	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад байлгах зорилгоор 20 сумын бог малын 10,6 мянган хээлтүүлэгчийг 86 суурьт ялган төвлөрүүлсэн. Эрдэнэцогт сум 500 сарлагт үзлэг ангилалт хийсэн. Үүний үр дүнд амьдын жингийн үзүүлэлт, ашиг шимийн үзүүлэлт хангаагүй 46 толгой малыг заазлав. Амьдын жингийн үзүүлэлт аймгийн дунджаар өсвөр хуц 33 кг, бүдүүн хуц 55 кг, өсвөр ухна 22 кг, бүдүүн ухна 41 кг амьдын жинтэй байгаа нь тухайн төрлийн малын амьдын жингийн стандартыг хангаж байна. Жаргалант, Баянбулаг, Эрдэнэцогт сумын бог малын хээлтүүлэгч 2570, сарлаг 350-ыг ээмэглэн бүртгэлжүүлсэн. Баянцагаан сумд Үржлийн цөм сүргийг бүрдүүлэх зорилгоор хээлтэгч худалдан авах 20,0 сая, Цөм сүргийн малын хашаа авахад 20,0 сая, бүх сумдад Малын ашиг шимийг хэмжих багаж, тоног төхөөрөмж авахад 20,0 сая төгрөгийг төсвийн	
----	--	--	--	--	---	--

						тодотголоор батлуулсан бөгөөд холбогдох аж ахуй нэгжтэй гэрээ байгуулах шатандаа байна.	
80		3.3.4. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүлэмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх		Тариалан бүхий сумдад шинээр 1 хүлэмжийн аж ахуйг бий болгон 4*8 хэмжээтэй 25 хүлэмж авч тариаланчдад олгон хамгаалагдсан хөрсний тариалалтыг 30 хувиар өсгөнө.		Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлж, өрхийн тариалангийн үйл ажиллагааг өргөжүүлэн хүн амын хүнсний хангамжийг өсгөх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Алтан сапа” ХХК-тай гэрээ байгуулан хүлэмжийн худалдааг аймгийн төвд 2 өдрийн хугацаанд зохион байгуулсан. Баянхонгор сум 3*4 хэмжээтэй 6 ширхэг буюу 72 м2, 4*6 хэмжээтэй 7 ширхэг буюу 168 м2, 4*8 хэмжээтэй 8 ширхэг буюу 256 м2, Баян-Өндөр сумын 1 ширхэг буюу 120 м2, Хүрээмарал 1 ширхэг буюу 12 м2, Жаргалант 3 ширхэг буюу 96 м2, Баянцагаан 1 буюу ширхэг 12 м2 нийт 27 ширхэг 736 м2 37,5 сая төгрөгийн үнэ бүхий хүлэмжийг иргэд өөрсдийн хөрөнгөөр худалдан авсан ба компанийн зүгээс урамшуулал болгож 3,5 сая төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг услалтын системийг үнэ төлбөргүйгээр иргэдэд олгосон. Дээрх	

						хүлэмжийг хаврын тариалалтад ашиглаж эхлээд байгаа ба тариалалтын эцсийн дүн мэдээ гараагүй байна.	
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
81	4.1. Эх байгаль-Ногоон байгууламж	4.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд шат дараатайгаар 500.000 доошгүй тарьц суулгацыг үржүүлж ногоон байгууламжид гаргана. Мөн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрыг өргөтгөж тарьц суулгацыг нэмэгдүүлж ажиллана			Аймгийн хэмжээнд 500.000 тарьц суулгацыг тариж амьдралтын хувийг 80-иас дээш хувьд хүргэж, хайс хамгаалалт, арчилгаа усалгааны асуудлыг шийдвэрлэсэн байна.	Сум дундын ойн анги Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааг өргөтгөж орон нутгийн тарьц суулгацыг бүрэн хангах зорилгоор тарьц суулгац нийлүүлэх, машин, техник хэрэгсэл нийлүүлэх, багаж тоног төхөөрөмж нийлүүлэх, хөрс боловсруулалтын ажил, хүлэмж барих, зоорь барих, хашаа татах, худаг гаргах, 8*6 хэмжээ мод тарьц, суулгац худалдаалах байр барих гэх мэт 4 төрлийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан. Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газар хагас жилийн байдлаар улиас, бургас, сухай 3 төрлийн нийт 55 мянган ширхэг хараңдаан суулгацыг 55 дэвсэг талбайд тариалалт хийж бүрэн дууссан. Мөн 10 төрлийн 2000 ширхэг мод тарьц суулгацыг	

						мод үржүүлгийн газрын эх ургамлын талбайд тариалах ажил 50 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Бүх нийтээр мод тарих өдрийн хаврын тарилтаар аймгийн хэмжээнд 81,069 ширхэг мод шинээр тарьж, усалгаа арчилгааг холбогдох сумд бүрэн хариуцан ажиллаж байна. Амьдралтын хувийг 09 дүгээр сард тооцно	
82	4.1.2. Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож мод үржүүлгийн талбай байгуулах			Мод үржүүлгийн талбайг хариуцан хамгаалж, арчилж ургуулах үйл ажиллагааны зардал болон талбайг 3га газраас доошгүй нэмэгдүүлж хайс хашлагыг сунган, 2300 ширхэг тарьц суулгацыг тарьж амьдралтыг 80 хувиас дээш хүргэсэн байна.		Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож, мод үржүүлгийн талбай байгуулах ажлын тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч аж ахуйн нэгж оролцоогүй тул сумаас ирсэн хүсэлтийн дагуу Өлзийт сумр уу эрх шилжүүлэхээр ажиллаж байна.	
83	4.1.3. Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах			Аймгийн төвийн болон төв суурин газруудын ногоон бүсд таригдах тарьц суулгацыг бэлтгэх агро үржүүлгийн төв		Шинэ суурьшлын мод үржүүлгийн газар байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, Даяар трейд ХХК-тай гэрээ байгуулсан. Мөн тус мод үржүүлгийн газар шаардлагатай багаж тоног	

				байгуулна		төхөөрөмж, үр үрсэлгээг худалдан авсан. Ажлын гүйцэтгэл 30 хувьтай, гэрээнд тусгасны дагуу 07 дугаар сарын 30-нд гэхэд бүрэн дуусгахаар ажиллаж байна.	
84		4.1.4. Говийн бүсийн сумдыг модны тарьц суулгацаар хангах Богд сумын Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг сайжруулах		Үр, тарьц суулгац үржүүлэх 8*20 хэмжээтэй хүлэмж, услалтын системийн тоног төхөөрөмжтэй болно		Богд сумын мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2 га-д усалгааны систем, усны нөөцийн савыг шинээр байршуулж, 8*30 хэмжээтэй хүлэмж барьсан. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц орон тоонд Богд сумын мод үржүүлгийн газарт ажиллах боловсон хүчин, ажлын байр байхгүй тул бүтэц, орон тоог нэмэгдүүлж цаашдын үйл ажиллагааг хангаж ажиллана.	
85		4.1.5. Бүх нийтээр мод тарих хавар намрын өдрүүд, дэлхийн усны өдөр, Мазаалай хамгаалах өдөр, нүүдлийн шувуудыг хамгаалах өдөр, Цаг уурчдын өдөр, ирвэс хамгаалах өдөр, ой, ургамал хамгаалах өдөр зэрэг салбарын 28 тэмдэглэлт өдрүүдээр сургалт сурталчилгаа хийх		Танхимын болон цахим сургалтыг 60-аас доошгүй удаа зохион байгуулж нийт 10000 иргэнд хүргэсэн байна.		Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/55 дугаар тушаалаар "Дэлхийн усны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдсон. Тус ажлын хэсэг 3 төрлийн 17 ажил арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган 3 дугаар сарын 14-өөс	

						<p>4 дүгээр сарын 20-ыг хүртэл зохион байгуулж 40 цахим болон танхимын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 14,000 иргэнийг хамруулсан. Мазаалай хамгаалах өдрөөр мазаалайн талаар мэдээллүүдийн тэмдэглэл хөтлөх үйл ажиллагаанд 65 сурагч, цэцэрлэгүүдийн 4-5 настай хүүхдүүдэд 2 сарын төсөлт сургалт явуулж 96 хүүхэд, Мазаалай түлхүүрийн оосор хийх уралдаан зарлан 51 хүүхэд, эцэг эхчүүдийг тус тус хамруулсан. Цаг уурчдын өдрөөр Ус цаг, уур орчны шинжилгээний төвөөс цаг уурын салбарт ажиллагсдын уулзалтыг зохион байгуулсан. Мөн "Бүх нийтээр мод тарих өдөр", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны хаврын мод тарих өдрийг зохион байгуулсан.</p>	
86		4.1.6. Түйн голын бургасанд хортон шавьжны устгал хийх		Түйн голын бургасны хортон шавьжийн устгалийг 3.5 га талбайд хийлгэж байгалийн аясаар сэргэн ургах нөхцлийг		Хугацаа болоогүй.	

				бүрдүүлнэ.			
87		4.1.7. Түйн голын байгалийн үерээр эвдэгдсэн хэсгийг шулуутгах		Богд сумын Хориултаас татуурга хүртэл 500м зайд Түйн голыг үндсэн голдиролд оруулж голын ай савыг хэвийн голдиролд оруулсан байна.		Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Түйн голыг үндсэн голдиролд оруулж усны алдагдлыг бууруулах далан байгуулах тухай” А/278 захирамжийн дагуу гүйцэтгэгч байгууллагатай гэрээг байгуулж Түйн голын гольдролыг үндсэн голдиролд оруулах, Богд сумын төвийн ундны усны эх үүсвэрийг сэргээх, хээрээр ус алдах эрсдэлийг бууруулах зорилгоор Татуургын булаг орчимд 2 м өргөн, 400 метр урттай далан байгуулах ажлыг эхлүүлсэн. Далан байгуулах ажлын гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байгаа бөгөөд 06 дугаар сард ажлыг хүлээн авна.	
88		4.1.8. Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тооцуулах.		Байгаль орчинд учруулсан үнэлгээг тооцуулан гарсан хохирлыг бүрэн барагдуулах.		МХГ-ын тайлан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022 оны 01/53 дугаар удирдамжийн дагуу Ой, ан, байгалийн ургамал хууль бусаар бэлтгэх, агнах, барих, худалдаалах, тээвэрлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалтын	

						<p>удирдамжийг 20 сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 13 заалттай 2 зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>2022 оны эхний хагас жилд хүрээлэн буй орчны эсрэг 3 хэрэгт байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээ хийлгүүлж мөрдөн шалгах ажиллагааны явцад болон шүүхийн шатанд 761,2 мянган төгрөгийг төлүүлсэн.</p>	
89	4.1.9. Аймгийн хэмжээний цөлжиж буй газрын судалгааг хийлгэх			Аймгийн нутаг дэвсгэрт цөлжиж буй газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хүлээн авсан байна.		Аймгийн хэмжээний цөлжиж буй газрын судалгааг хийлгэх зөвлөх үйлчилгээний ажлын сонгон шалгаруулалтын 3 удаа зарласан боловч аж ахуйн нэгж шалгараагүй тул шууд гэрээ байгуулахаар ажиллаж байна.	
90	4.1.10. Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтад байнгын хяналт тавих			Усны боломжит нөөцөд тохирсон ус ашиглалт, ус ашиглах гэрээ, ус бохирдуулсны төлбөрийн гэрээний биелэлтийг хянах, ус, рашаан ашигласны болон ус бохирдуулсны төлбөрийн биелэлтэд		Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтад хяналт тавих ажлын төлөвлөгөөг гарган баталсан. Төлөвлөгөөний дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд ажиллана. Тус ажлын хүрээнд	

					сар бүр хяналт тавина.		ус ашиглах гэрээ, ус бохирдуулсны төлбөр, төлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.	
91		4.1.11. Бөөнцагаан нуур-Байдраг голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах			Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж эхэлснээр аймгийн хэмжээнд усны талаар баримтлах бодлогын баримт бичигтэй болсон байна.		Бөөнцагаан нуур - Байдраг голын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг усны мэргэжлийн байгууллага болох Монхидроконстракшн ХХК-тай хамтран боловсруулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогоор суурь судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд 09 дүгээр сард Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанаас явцын хяналтыг тогтмол зохион байгуулж, судалгааны ажилд хамтран оролцож байна	
92		4.1.12. Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх			Гангийн эрсдэл буурна.		Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 05 дугаар сард 2 удаа зохион байгуулсан. Нийт 2 удаагийн гаралтад аймгийн нийт нутгийн 35-50 хувийг хамруулж хур тунадасыг нэмэгдүүлсэн. Ялангуяа Богд, Жинст, Гурванбулаг сумын	

						нутгаар олон жилийн дунджаас 1,5-9,4 миллиметрээр их хур тунадас орсон.	
93		4.1.13. Бөөнцагаан нууранд шувуу ажиглах байр барих			Бөөнцагаан нуурыг аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлсэн байна.	Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс Баацагаан сумын Товгор 5-р багийн Бөөнцагаан нуурын эрэг дээр шувуу ажиглах байрыг барих ажлын худалдан авах ажиллагаа зарласан. Одоогоор гүйцэтгэгч шалгараагүй байна.	
94		4.1.14. Зэрлэг амьтдын байршил бүхий газруудад өвс, хужир тавьж өгөх (биотехникийн арга хэмжээ авах)			Амьтад идэш, тэжээлийн хомсдолд орохоос сэргийлж, амьдрах орчныг сайжруулна.	Аймгийн хэмжээнд зарим сумдын амьтдын байршил бүхий газруудад 2022 оны 01-р сарын 05-ний өдрөөс 04-р сарын 01-ний өдрийн хооронд нийт 10,5 тонн хужир, 120 боодол өвс, 65 кг Жамц давс байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Мөн 2022 оны 05 дугаар сарын 01-05-ны хооронд Шинэжинст сумын Сэгс цагаан богд уул орчинд Мазаалай баавгайн амьдрах орчны бүсэд ажиллаж 7 цэгт, 11 тэжээлийн саванд, 28 шуудай хорголжин тэжээлийг байршуулан биотехникийг арга хэмжээ авч, орчны торыг засварлаж, үсний дээж,	

						баасны дээжийг шинжилгээнд авч ажилласан.	
95	4.1.15. Аялал жуулчлалын нөөц газруудын судалгааг эрдэмтдийн багтай хамтран хийх			Аймгийн аялал жуулчлалын онцлог нөөц газрууд, эрдэм шинжилгээний тодорхойлолттой болж, эдийн засгийн эргэлтэд орох нөхцөл бүрдэнэ.		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлтэй хамтран аялал жуулчлалын нөөц газрын судалгааг 2022 оны III улиралд багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байна.	
96	4.1.16. Аялал жуулчлалын нөөц газар Их Богд хайрханы Цонж орчмыг тохижуулж, аяллын маршрутыг тогтоох			Дотоод, гадаадын аялагчдын аялах нөхцөл бүрдсэн байна.		Их Богд уулын Цонжид аялал жуулчлалын Отоглох цэг байгуулахаар "Ойн их хишиг" ХХК-тай гэрээ байгуулсан ба 2022 оны 06 дугаар сарын 25-нд гэхэд ажлыг дуусган хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	
97	4.1.17. Аялал жуулчлалын эвент арга хэмжээ, сарлагийн баяр, өвлийн наадам, тэмээний баяр, Ай Ти Эм арга хэмжээнд оролцох			Дотоодын аялагчдыг 72 мянга, гадаадын аялагчдыг 500-д хүргэсэн байна.		Баянхонгор аймгийн аялал жуулчлалын салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгах, төр хувийн хэвшил, орон нутгийн иргэд, нөхөрлөл бүлгүүдийн уялдаа холбоог сайжруулж орон нутагт аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилгоор	

						Баянхонгор аймаг дахь Аялал жуулчлалын салбарын зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22-нд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл 60 орчим хүн оролцсон. Тус зөвлөгөөнийг зохион байгуулснаар төр, хувийн хэвшил, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, тухайн жилд ирэх жуулчдын сэтгэл ханамж, үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.	
98		4.1.18. Аймгийн хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх			Хог хаягдлын улмаас эвдэрсэн 6 га газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийсэн байна.	Хугацаа болоогүй.	
99		4.1.19. Шинэ хогийн цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулах			Стандартын шаардлага хангасан ландфилийн хогийн цэгийг стандартын дагуу хийсэн байна. /100м*100м буюу 5 га	Өлзийт сумын газар нутагт аймгийн төвөөс 13 км-ын зайд 100х70м харьцаатай, доошоо 4 метрийн гүн, дээшээ 4 метрийн шороон далан, сайжруулсан замтай Баянхонгор сумын төвлөрсөн	

				газар/		шинэ хогийн цэг байгуулсан.	
100		4.1.20. Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэгүүдийг байгуулах		Хоёрдогч түүхий эд худалдан авах 6 цэгийг бий болгон хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж, хог хаягдлыг багасгана.		Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэг байгуулах хурлыг Баянхонгор сум, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны 05 дугаар сарын 18-нд зохион байгуулж, багийн Засаг дарга нараас хоёрдогч түүхий эд худалдан авах цэг байгуулахад тохиромжтой газрын саналыг ирүүлэхээр шийдвэрлэсэн.	
101		4.1.21. Зорилтот өрхийг чип /CHIP/ багцаар хангах /оролцоо/		Зорилтот бүлгийн 100 өрхийг багцаар хангаж утааг бууруулахад хувь нэмэр оруулсан байна.		Зорилтот 10 өрхийг 2,2 сая төгрөгийн өртөг бүхий /CHIP/ багцад хамруулсан. Дээрх багцын 60 хувь буюу 1,3 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сан, НҮБ-ын хөгжлийн сангаас, 40 хувь буюу 880,0 мянган төгрөгийг иргэд хувиасаа гаргасан.	
ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
102	5.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал	5.1.1. Арван мянгатын хатуу хучилттай 1.2 км зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх		Баянхонгор сумын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.		Арван мянгатын хатуу хучилттай 1.2 км замын тендер сонгон шалгаруулалтад “Тэнгэрийн-Уул” ХХК шалгарч, гэрээ байгуулсан ба босоо бордюр суулгаж, явган хүний замын	

						ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 60%-тай байна	
103	5.1.2. Аймгийн төв доторх эвдэрсэн 1000м2 талбайд замын нөхөөс хийх			Авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.		Их богд зам ХХК тендерт шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 50 хувьтай. 07 дугаар сарын 01-н гэхэд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	
104	5.1.3. Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх			Баянхонгор сумын өнгө үзэмж сайжирч авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.		Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх ажлыг Их богд зам ХХК тендерт шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 30%-тай байна.	
105	5.1.4. Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын урд уулзвар хүртэлх 750 метр замд хатуу хучилттай авто зам барих			Баянхонгор сумын өнгө үзэмж сайжирч авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна.		Их богд зам ХХК тендерт шалгарч, гэрээ байгуулагдсан бөгөөд газар шорооны ажил бүрэн дууссан, ажлын явц 70%-тай байна.	
106	5.1.5. Есөн-Эрдэнэ захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх зам дагуу явган хүний зам хийх			Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.		Есөн-Эрдэнэ захаас Хонгор хотхон хүртэл 1,2 км Хатуу хучилттай замын ажлыг явган хүний замын хамт "Их богд зам" ХХК тендерт шалгарч, бүрэн ашиглалтад оруулсан.	
107	5.1.6. Эрдэнэмандал сургууль орчмын бүсийг стандарт			Зам тээврийн осол буурч, хүний эрх		Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах	

		шаардлагад нийцүүлэн тохижуулах		хангагдсан байна.		сургуулийн сургууль орчмын бүсийг тохижуулах ажлын тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, “Итгэлт тайж” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн, явц 50%-тай байна	
108		5.1.7. Аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах		Нэн шаардлагатай 350 м2 уулзвар, орц гарцыг шинэчилнэ.		Аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах ажилд “Их богд зам” ХХК шалгарч газар шорооны ажлыг бүрэн дуусгасан, ажлын явц 50%-тай байна.	
109		5.1.8. Шаардлагатай сумдын шороон замын зураг төсөв боловсруулах, засвар үйлчилгээ хийх (Баянговь, Баянлиг, Баацагаан, Баянцагаан, Шинэжинст, Эрдэнэцогт, Баянөндөр)		Зураг төсөв боловсруулагдсан байна. Байгалийн гамшгаар эвдэгдсэн шороон замууд засагдсанаар иргэдийн аюулгүй зорчих боломж бүрдэнэ		Зураг төсөл боловсруулалтын шатанд явагдаж байгаа	
110		5.1.9. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх		Шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай 10 км авто замын ажлыг эхлүүлсэн байна.		Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг Түм дэлгэрэх ХХК тендерт шалгарч, гэрээг байгуулсан.	
111		5.1.10. Шаргалжуут тосгоны замын засвар хийх		Амрагчдын ая тухтай, осол аварггүй зорчих нөхцлийг бүрдүүлсэн		Шаргалжуут тосгоны замын засвар, арчлалтыг замын сангийн 5,0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн	

				байна.		ашиглалтад оруулсан.	
112		5.1.11. Хот хоорондын ачаа, тээвэр, сум хоорондын тээвэр, нүүрс, түлээ, амьд мал худалдаалах нэгдсэн цэг байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх		Нэгдсэн зохион байгуулалтад орж аймгийн төлөвлөлт, өнгө үзэмж сайжирна.		Зураг төсөв боловсруулагдаж байгаа 2023 оны төсөвт тусгагдсан.	
113		5.1.12. Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээг хийх		Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц сайжирч иргэд хувийн байр сууц барьж ая тухтай амьдрах орчин бүрдэх эхлэлийг тавина.		Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж үнэлгээний шатандаа байна.	
114		5.1.13. Баянхонгор сумын инженерийн шугам сүлжээний тооллогын ажлыг эхлүүлж мэдээллийн санд оруулах		Шугам сүлжээний насжилт, өндөржилтийг бүрэн тооцох боломж бүрдэнэ.		Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж энэ оны 3 дугаар улиралд ажлыг эхлүүлхээр төлөвлөөд байна.	
115		5.1.14. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийг хийх		Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлсэн байна.		Баянхонгор аймгийн 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна.	
116		5.1.15. Шаардлагатай газруудад цахилгаан шугам, дэд станцын өргөтгөл хийх (5.6 км иж бүрэн шугам, 2 дэд станцын өргөтгөл		300 орчим хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж,		Шаардлагатай газруудад цахилгаан шугам, дэд станцын өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон	

		хийх)			хүчдэлийн түвшинг сайжруулна.		шалгаруулж "Гарьд системс" ХХК-тай гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 50%-тай байна.	
117		5.1.16. Баацагаан сумын цаг уурын тоног төхөөрөмжийг шинэчлэх			Автомат станц тавьснаар цаг уурын мэдээллийг шуурхай авах нөхцөл бүрдэнэ.		Баацагаан сумын хөдөө аж ахуйн харуулд QR -1000 цаг уурын автомат станц хангалтаар авч байрлуулан хэвийн ажиллагааг шалгаж байна.	
118		5.1.17. Хүрээмарал сумын Сувраа уулын орой дахь Жи-Мобайлын сүлжээг дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл хийх			Баянбулаг,Гурванбулаг, Заг, Бууцагаан сумдын багийн иргэд Жи-Мобайлын сүлжээг ашиглах боломжтой болно.		Хүрээмарал сумын Сувраа уулын орой дахь Жи-Мобайлын сүлжээг дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл хийх ажлын гүйцэтгэгч ААН-тэй гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 30%-тай байна.	
119		5.1.18. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх			Дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.		Дулааны станцын гүйцэтгэгч БНСУ-ын "Бюксан инженеринг" ХХК-тай гэрээ байгуулж барилгын суурийн ажлыг эхлүүлээд байна.	
120		5.1.19. Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх			Иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх таатай орчин нөхцөл бүрдсэн байна.		Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.	

						Ажлын явц 10%-тай байна.	
121	5.1.20. Баацагаан, Галуут, Эрдэнэцогт сумдад "Сумын төвийн шинэчлэл" төсөл хэрэгжүүлэх			Галуут, Эрдэнэцогт сумдын сумын төвийн шинэчлэлийн ажлыг ашиглалтад оруулж Баацагаан сумын сумын төвийн шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн байна.		Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 50%-тай үргэлжилж байна. Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Алегротонер констракшн" ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлууд нь 2022 оны 10 дугаар сард багтаан ашиглалтад орно. Баацагаан сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Рино инженеринг" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	
122	5.1.21. Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх			Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлсэн байна.		Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна.	
123	5.1.22. Шинэ суурьшлын бүсэд А, Б блок 1500 айлын 30 орон сууцны хорооллыг байгуулах			2 нийтийн орон сууцны барилгыг байнгын ашиглалтад оруулж, шинээр 2 барилгын угсралтын ажлыг эхлүүлсэн байна.		Шинэ суурьшилын бүсэд 100 айлын блок орон сууцны барилгын угсралтын ажлыг "Хаш гоёо" ХХК, Баянхонгор эко дулаан ХХК 2021 онд эхлүүлсэн ба 2022 оны 06 сард ашиглалтад оруулахаар	

						төлөвлөн ажиллаж байна	
124	5.1.23. Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх			Баянхонгор сумын 10 дугаар байрыг ашиглалтад оруулж, 1 дүгээр байрыг дахин төлөвлөлтөд оруулах ажлыг эхлүүлсэн байна.		Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг буулган шинээр 140 айлын орон сууц барихаар барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Зүүн шанд” ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Тус барилгыг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Рашаант 10-р багийн 1-р байрны дахин төлөвлөлтийн ажлын гүйцэтгэгчээр Би ай эм би ХХК шалгарсан бөгөөд Аймгийн засаг дарга, оршин суугчид, гүйцэтгэгч 3 талт гэрээ байгуулсан. Буулгалтын ажил хийгдэж 7 давхар 49 айлын орон сууцны угсралтын ажлыг эхлүүлсэн. Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлэхээр 5 давхар орон сууцны барилгын 1 маягийн зургийн боловсруулалтын ажил хийгдэж байна.	
125	5.1.24. Баянхонгор сумын Номгон 1-р багийн 514 дүгээр байрыг их			Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөл		Баянхонгор сумын Номгон 1-р багийн 514 байрны их засварын ажлын гүйцэтгэгчээр	

		засварт оруулах			сайжирсан байна.		"Алегротонер констракшн" ХХК хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 80%-тай байна.	
126		5.1.25. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл			Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан байна.		Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.	
127		5.1.26. Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлэх			Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн байна.		Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Б софт" ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлэхээр бэлтгэл хангаад байна.	
128		5.1.27. Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын бүс бий болж байгаатай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах			Ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.		Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй	
129		5.1.28. Баянхонгор сумын ундны усны харуул хамгаалалт			Аймгийн нийт хүн амын ундны ус нь эрүүл, аюулгүй байна.		Баянхонгор сумын ундны усны харуул хамгаалалтын ажлын гэрээг орон нутгийн төсвийн 20,0 сая төгрөгөөр Даяар хүч ХХК-тай байгуулан хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж	

						байна.	
130		5.1.29. Үүрэн холбооны сүлжээ			Хөдөөгийн малчид гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ	Үүрэн холбооны сүлжээний ажил нь 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хасагдсан.	
ЗУРГАА. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ							
131		6.1.1. Архивын байрыг иж бүрэн камержуулах			Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдал хангагдана.	айети юнипикэшн ХХК-тай шууд гэрээ байгуулан архивын байрыг камержуулах ажил 70 хувьтай явагдаж байна.	
132	6.1. Аюулгүй нийгэм, амар тайлан орчин	6.1.2. Иргэдийн хаягийн шинэчлэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шинэчлэх			Төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.	Тус арга хэмжээг нийт 12 ажлыг хийхээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 75 хувь буюу шинэ болон хуучин хаягийг мэдээллийн санд , газар дээр , багийн дарга нартай, ГХБХБГ-тай тулгалт хийж дуусган тус газарт 6535 хаягийг баталгаажуулалт хийлгэхээр хүргүүлсэн.Одоогоор хариу ирүүлээгүй байна.	
133		6.1.3. Жаргалант, Богд сумдын			Цагдаагийн тасгийн	Цагдаагийн газрын Богд,	

		цагдаагийн тасгийг шинэ байртай болох			алба хаагчдын ажиллах, амьдрах ая тухтай орчин нөхцөл бүрдсэн байна.		Жаргалант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг ЦЕГ-аас зарлаж, "Хоролбагана констракшн" ХХК шалгарч, 598,897,508 /таван зуун ерэн найман сая найман зуун ерэн долоон мянга таван зуун найман/ төгрөгөөр гэрээ байгуулан, барилга баригдах ажил 30 хувьтай явагдаж байна.	
134		6.1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогч нарын ар гэрийнхэнтэйгээ уулзах өрөөг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулж, орчин нөхцөлийг сайжруулах			Хоригдогч ар гэрийнхэнтэйгээ уулзах нөхцөл бололцоогоор хангагдсан байна.		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогч нарын ар гэрийнхэнтэйгээ уулзах өрөөг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулж, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг Баянтал ХХК гүйцэтгэн, ашиглатад оруулж, 3 хоригдогч нарыг ар гэрийнхэнтэй нь уулзуулж, хамт байх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.	
135		6.1.5. Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг зохион байгуулах, салбар зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дэмжлэг			Зөвлөлийн үйл ажиллагаа сайжирсан байна.		Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг зохион байгуулах, салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр	

		үзүүлэх				захирамжаар батлуулан хилийн 0166-р ангийн үйл ажиллагаатай танилцан, 5.0 сая төгрөгийн үнэ бүхий хэрэгсэл гардуулан өгч, дэмжлэг үзүүлэн ажилласан.	
136		6.1.6. Хилийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын цэргийн байранд халаалтын нэгдсэн шугам, хилийн 0112 дугаар салбар /Цагаанбогд/-ын албаны байруудад засвар хийх ажилд дэмжлэг үзүүлэх			Цэргийн алба хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл зохих түвшинд сайжирсан байна.	Хилийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын цэргийн байранд халаалтын нэгдсэн шугам, хилийн 0112 дугаар салбар /Цагаанбогд/-ын албаны байруудад засвар хийх ажлын гэрээ шууд байгуулах шатандаа явж байна.	
137		6.1.7. Баянхонгор сумын 2, 3, 7 багийн гудамны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх			Багийн иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна.	Тендер нь одоогийн байдлаар зарлагдаагүй ба сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг байгуулах шатандаа байна.	
138	6.2. Батлан хамгаалах салбар	6.2.1. Баянхонгор аймгаас 2021 онд татагдсан хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн алба хаагчдыг эргэх, Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги салбаруудын үйл ажиллагаатай танилцах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх			Баянхонгор аймгаас 2021 онд татагдсан хугацаат цэргийн алба хааж байгаа 300 цэргийн алба хаагчдын алба хаах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн Засаг даргын хугацаат цэргийн алба хаагч нарыг эргэх тухай 2022 оны А/78 дугаар захирамжийн дагуу Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан Батлан хамгаалахын сайдтай 2022 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хүрээнд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн	

						алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах зорилгоор ажлын хэсэг томилон хонгор нутгийн цэрэг дайчдаа эргэх арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын орлогч Б.Батсууриар ахлуулсан, Цэргийн штабын дарга, хурандаа Г.Нэмэхбаяр болон бусад алба хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 02 дугаар сарын 23-аас 03 сарын 07-ны хугацаанд Улаанбаатар хот дахь 032, 326 дугаар анги болон Өвөрхангай аймаг дахь 256 дугаар анги, Өмнөговь аймаг хилийн 0166 дугаар анги, Баянхонгор аймаг дахь 339 дүгээр ангид албаа хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдаа эргэлээ.	
139		6.2.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит Батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдах спортын болон марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах		Батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.		“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын 2022 оны А/141 дугаар захирамжаар батлагдсан хөтөлбөрийн дагуу 03 дугаар сарын 10-ний өдрөөс 03 дугаар сарын 18-ний өдрүүдэд	

						Зэвсэгт хүчний анги, салбарууд, төрийн цэргийн болон хууль байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний зарим анги, салбаруудад дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж явуулсан.	
140		6.2.3. Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг зохион байгуулах "Цэргийн алба зохион байгуулах заавар"-т нийцсэн хөдөлгөөнт сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх			Цэргийн алба зохион байгуулах зааварт нийцсэн хөдөлгөөнт сургалтын баазтай болсон байна.	Батлан хамгаалахын сайд Баянхонгор аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу сургалтын матерриаллаг бааз бүрдүүлэхийн тулд 20 тонны контейнер худалдан авсан.	
141		6.2.4. Улс, аймаг Засаг даргын нэрэмжит, аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээн зохион байгуулах			Ерөнхий боловсролын сургуулийн 600 сурагчдад сэтгэл зүйн болон бие бялдарын өв тэгш хүмүүжил олгосон байна.	Батлан хамгаалах яамны 111 жилийн ой, Зэвсэгт хүчний 101 жилийн ой, Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг өсвөр үе хүүхэд залуучуудад сурталчлах, цэрэг, эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, баг хамт олноор ажиллах чадвар олгоход зорилгоор	

						аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг зохион байгуулан явууллаа.		
142		6.2.5. Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн цэргийн гал тогооны барилга шинээр барих			Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдал хангагдсан байна.	Барилгын доод давхарын зоорийн давхар, 1 давхарын хэв шахмал тулц багана хийж дууссан гүйцэтгэл 15 хувьтай. Шинээр гал тогооны барилга баригдсанаар Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн 500 гаруй ажилтан, мөн цэрэгт ирсэн 150 гаруй албан хаагчдын нийт 650 хүний хүнсний эрүүл аюулгүй байдал хангагдсан байна.		
ДОЛОО. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
143	7.1. Ухаалаг засаглал	7.1.1. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, команд штаб, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах			Гамшгаас хамгаалах "Иж бүрэн" команд штабын сургууль хийгдсэн байна	Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6 сая төгрөг	Аймгийн Засаг даргын 2022 оны А/249р захирамжаар Баянлиг, Өлзийт сумдад гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль зохион байгуулахаар төлөвлөсөн. 2022 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Өлзийт суманд сургууль дадлагыг зохион байгуулав. Сургууль дадлагад	

						тус сумын гамшгаас хамгаалах мэрэгжлийн ангийн нийт 120 ажилтан албан хаагч оролцсон. Сумын гамшгаас хамгаалах бэлтэл бэлэн байдлыг бүрэн хангуулж, гамшгийн үеийн мэдээ мэдээллээр хангасан.	
144		7.1.2. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх		Төрийн албаны шалгалтанд шаардагдах тоног төхөөрөмжүүд шинэчлэгдсэн байна.	Жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 65 сая төгрөг	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр захирамжаар "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжлэг үзүүлэх, төрийн албаны шалгалт авахад техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх санхүүжилтын асуудлыг шийдвэрлэж, салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 23.0 сая, шалгалт авах 20 ширхэг нөтбүүкний зардал 42,0 сая, нийт 65,0 сая төгрөгийг зарцуулав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2022 оны 05 дугаар сарын байдлаар 5 удаагийн давхардсан тоогоор 200 гаруй сул орон тоог нийтэд зарлаж,	

						50 гаруй сул орон тоог нөхөхөөр салбар зөвлөлийн тогтоолоор иргэний нэрийг дэвшүүллээ. Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба аяныг өрнүүлж, байгууллагын ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, салбар зөвлөлөөс 10 гаруй удаагийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.	
145	7.1.3. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийлгэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах			Хэрэглэгчийн үнэлгээг өмнө оноос 5-с доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 15 сая төгрөг	Аймгийн Засаг даргын 2022 оны А/230 дугаар захирамжаар үнэлгээ хийх захирамж гаргасан. Судалгаа хийлгэх төрийн бус байгууллагыг судалж байна	
146	7.1.4. “Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар” судалгаа хийх			Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, халамж, даатгал, нийгмийн бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний чанарыг тодорхойлж, зөрчил дутагдлыг арилгана.		Захирамжийн төсөл, судалгааны удирдамжийг боловсруулсан.	
147	7.1.5. E-Mongolia системийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх			Лавлагаа, мэдээлэл 520 төрлөөр нэмэгдэж иргэдэд хүрэх төрийн		E-Mongolia системийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд таниулах, хэрэглээг	

		зорилгоор удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах		үйлчилгээг ойртуулна.		нэмэгдүүлэх зорилгоор "Дижитал Баянхонгор" арга хэмжээг Цахим хөгжил харилцаа холбооны яам, E-Mongolia академитай хамтран 2022 оны 04 дүгээр 08 зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаанд төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, банк санхүү, үүрэн холбооны операторууд нийт 46 байгууллага нэгдэн оролцож аймагт шинээр 31 төрлийн үйлчилгээ нэмэгдэж нийт 246 үйлчилгээг өргөжүүлээд байна. Аймгийн хэмжээнд нийт 1264 үйлчилгээг хагас жилийн байдлаар цахимаар 4500 иргэнд шуурхай олгоод байна. 20 сумын операторын доголдсон үйлчилгээг тухай бүр шийдвэрлэж удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна	
148		7.1.6. “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. Үндсэн сайтын нэмэлт хөгжүүлэлт 2. Сумдын сайтын нэмэлт хөгжүүлэлт		Аймгийн хэмжээний 1, сумдын 20 цахим хуудасны үйл ажиллагаа сайжирч, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ.		Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/182 дугаар захирамжийн дагуу "Интеллежинт технологи солушинс" ххк-тай гэрээ байгуулж гэрээний хугацааны дагуу 05 дугаар сарын 01-ний	

						өдөр эхний загвар цахим хуудастай танилцаж сайжруулалт, шинэчлэлийг тохиролцон 05 дугар сарын 17 н-ны өдөр сумдын албан ёсны цахим хуудсыг сум бүрийн хариуцсан мэргэжилтнүүдэд хандах эрхийг олгож ашиглалтын сургалтыг цахимар зохион байгуулж 06-р сарын 01-ны дотор үндсэн мэдээллийг бүрэн бүрэн оруулсн байхаар үүрэг өгөн ажиллав.	
149		7.1.6. “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. Дашбоард хөгжүүлэлт /Тоон мэдээллийн цахим хяналтын самбар/ 2. Иргэдийн санал гомдол илгээх систем			Аймгийн хэмжээний 192 төрлийн үндсэн тоон мэдээллийг иргэд, байгууллагууд авч, санал, гомдол илгээх шууд систем бий болно.	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/245 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сарын 25-ны өдөр "Интеллекент техноложн солушинс" ХХК-тай гэрээ байгуулахаар гэрээний төсөл боловсруулагдан ажиллаж байна.	
150		7.1.6. “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. "Цахим Баянхонгор" Гар утасны АПП + хөгжүүлэлт 2. Цахим мэдээллийн тайлангийн систем хөгжүүлэлт			Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/242 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сарын 25-ны өдөр "Эс Ти Юу солушнс" ХХК-тай гэрээ байгуулахаар гэрээний төсөл боловсруулагдан ажиллаж	

						байна.	
151	7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан программ хангамж хөгжүүлэх			Аймгийн хэмжээний нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг жуулчид, олон нийтэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.		Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/242 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сарын 25-ны өдөр "Баянхонгор аймгийн мэдээлэл технологийн төв"-тэй гэрээ байгуулахаар гэрээний төсөл боловсруулагдан ажиллаж байна.	
152	7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх			Аймгийн хэмжээний нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг жуулчид, олон нийтэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.		Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/243 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сарын 25-ны өдөр "Дижитал актив" ХХК-тай гэрээ байгуулахаар гэрээний төсөл боловсруулагдан ажиллаж байна.	
153	7.1.8. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, нэмэлтээр шаардлагатай системийн хөгжүүлэлтийг хийх			Эрүүл мэндийн үйлчилгээ бүрэн цахимжсан байна.		Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж байгаа ehealth програмын хүрээнд Оношилгоо, Эрүүл мэндийн салбаруудын анхан шатны маягтуудыг цахимжуулан ажиллаж байна. Цаашид нэмэлт хөгжүүлжлт	

						сайжруулалтыг хийн ажиллана.	
154		7.1.9. Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск (өөртөө үйлчлэх) машины систем хөгжүүлэн нэвтрүүлж, төрийн байгууллагууд болон нийтийн үйлчилгээний газруудад байршуулна			Аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээг 1 төхөөрөмжөөс авах боломжийг аймгийн төвийн 4 цэгт, 2 сумын төвд бий болгоно	Аймгийн Орон нутгийн Өмчийн газар удалдан авах ажиллагааны дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулах хүсэлт илгээж хүсэлтийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр тендер нээх хугацаатайгаар хүлээгдэж байна.	
155		7.1.10. Төрийн цахим шилжилтийн үр дүнг таниулах, тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх "Inspire 2022 цахим шилжилтийг хүн бүрт" төслийг хэрэгжүүлэх			Иргэд ажил амьдралдаа технологийн дэвшлийг хэрэглэж хэвшүүлэх	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу "Дижитал Баянхонгор" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. "Дижитал Баянхонгор" арга хэмжээний хүрээнд "Цахим шилжилтийг хүн бүрт" уриатай "Inspire 2022" арга хэмжээг Импасофт ХХК, Имтатс ХХК-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж 04 дүгээр сарын 27-30-ны өдөрдүүрэд зохион байгууллаа. "Inspire 2022" арга хэмжээгээр 400 гаруй иргэд төрийн албан хаагч, 800 гаруй ЕБС-ын ахлах ангийн	

						сурагчдад мэдээллийн технологийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулав. Мөн төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Сүпер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэвдийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.	
156		7.1.11. Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж			Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл сайжирч чадавхжсан байна.	20 сумын 40 багийн Засаг дарга нарыг унаажуулж тэдний ажиллах нөхцөлийг сайжруулсан.	
157		7.1.12. Сумдын газрын даамлуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх			Мэргэжлийн шаардлага, стандартад нийцсэн хүчин чадалтай компьютер тоног төхөөрөмжөөр хангагдана.	Dell -ийн i7-10-р үетэй процессор, 8GB шуурхай санах ойтой, 24 инчийн дэлгэцтэй 16 компьютер, 1 нөөтбүүхийг 53.2 сая төгрөгөөр авч 16 сумын газрын даамалд хүлээлгэн өгсөн. Орон нутгийн албан хаагчдыг тоног төхөөрөмжөөр хангасанаар газрын харилцааны үйлчилгээг шуурхай хүргэх, албан	

						хаагчийн ажиллах нөхцөл бүрдсэн	
158		7.1.13. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх		Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг 80-аас дээш хувьд хүргэсэн байна.		Орон нутагт хэрэгжиж байгаа 20 дэд хөтөлбөрийн санхүүжилтэд 100,0 сая төгрөгийг олгосон. Хөтөлбөрүүдэд санхүүжилт олгосноор тухайн хөтөлбөрийн хэрэгжилт чанаржиж зорилтот түвшинд хүрч ажилласан байна.	
159		7.1.14. www.bayankhongor.igovernment.mn хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санг нэвтрүүлнэ.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сантай болж хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн дээшилсэн байна.		Баянхонгор аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлж, аймгийн Засаг даргын харьяа 24 агентлаг, босоо удирдлагатай болон орон нутгийн өмчийн 9 байгууллага, 20 сумын Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 53 байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 1 штаб, 1 тасаг болон Төрийн албаны Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл зэрэг 9 бүтцийн нэгжийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны тайланг цахимаар авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломж бүрдсэн.	

						Байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн тайланг 24 агентлаг, 20 сумын Засаг даргын Тамгын газраас 2022 оны 04 дүгээр сард цахим санд нөхөж оруулсан ба 440 төрлийн тайлан оруулахаас 354 тайланг цахим санд оруулж, 80,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Цахим тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, байгууллагын 2022 оны эхний хагас жилийн тайланг авах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, тайланг авч эхэлсэн.	
160		7.1.15. Баянхонгор аймаг дахь терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх			Төлөвлөгөөний биелэлтийг 85 хувьд хүргэнэ.	Баянхонгор аймаг дахь терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, 55 хувьтай хэрэгжиж байна. Монгол Улсын терроризмтай тэмцэх зөвлөлөөс мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад 300 орчим төрийн албан хаагчийг хамруулан зохион байгуулж, 5.0 сая/төг-ийн үйл ажиллагаанд	

						дэмжлэг үзүүлэн ажилласан.	
161		7.1.16. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх			Төлөвлөгөөний биелэлтийг 85 хувьд хүргэнэ.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжаар Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. төлөвлөгөөний хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар хадгалагдаж байгаа хуурай 206.7 кг, шингэн 436.6 литр бодисыг устгал хийх компаниар устгуулан ажиллалаа.	
162	7.1. Ухаалаг засаглал	7.1.17. Хурлын ажлын албаны ажиллах хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашиныг шинэчлэх			Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй нь улмаас автомашин аваагүй болно	